

Appendix2.4-7 Screen Excerpt of Operating HOB



**УХЗ-ны зөв галалгааны тухай**

**А. Агаарын бохирдлын өнөөгийн төлөв байдал**


No.	Кадр	No.	Кадр
1a	PP1 Гарчиг	1b	PP2 Гарчиг




No.	Кадр	No.	Кадр
2	00076 УБ хотыг өндөр дээрээс харуулах	3	00079 УБ хотыг өндөр дээрээс харуулах



No.	Кадр	No.	Кадр
4	00081 УХЗ	5	00082 УХЗ



Но.		Кадр
6	PP3	Агаарын бохирдлын шалтгаан



**В. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй УХЗ-нууд**

Но.		Кадр	Но.		Кадр
7а	PP4	УБ хотод үйл ажиллагаа явуулж буй УХЗ-нууд	7б	PP5	УБ хотод үйл ажиллагаа явуулж буй УХЗ-нууд




**Улаанбаатар хотод байрлах 250 кВт-с дээших хүчин чадал бүхий УХЗ-нууд**  
(2011 оны эцсийн бүртгэлээр)



- Зуухны байгууламжийн тоо: 98
- Марк: 17 төрөл, 198 ш

УХЗ-ны төрөл	Тоо.ш	%	Галлагаа	шүүгч
БНХАУ болон дотоодын УХЗ	50 ш	27%	Гараар	байхгүй
HP-18	43 ш	23%	Гараар	байхгүй
Carborobot	30 ш	15%	Автомат	Cyclone
BZUI	20 ш	11%	Гараар	Байхгүй
DZL болон CSZL	10 ш	5.4%	Автомат	Scrubber
МУКНТ	10 ш	5.4%	Гараар	Cyclone



Но.		Кадр	Но.		Кадр
8	PP6	Босоо цилиндр УХЗ	9	PP7	HP-18



No.		Кадр	No.	.	Кадр
10	PP8	Carborobot	11	PP9	BZUI



No.		Кадр	No.	.	Кадр
12	PP10	DZL	13	PP11	MUKHT



**Ва. УХЗ-ны галлагааны талаар**

No.		Кадр	No.	.	Кадр
a1	NPP3	Нүүрсний төлөв байдал	a2	NPP4	Нүүрсний шаталт

**Нүүрс ба УХЗ**  
**1. Нүүрсийг илчлэгээр нь ангилал**

Ондор ← Илчлэг → Бага

Нүүрсний ангилал	Асууцалт	Бөгүүлсэн нүүрс	Халагч бүтээхсэн нүүрс	Лайгат (Lignite)
Илчлэг (kcal/kg)* Чөдөлзтгүй үед	> 8,400	8,100 ~ 8,400	7,900 ~ 8,100	5,800 ~ 7,300
Чийглэг (%)	< 10	< 15	15 ~ 30	30 ~ 60
Илчлэг (kcal/kg) Энгийн үед шатахад	6500 ~ 7000	6500 ~ 6500	4500 ~ 5500	2500 ~ 4500

**Нүүрс ба УХЗ**  
**2. Нүүрсний үзүүлэлт болон шатах процессийн онцлого**

Нүүрсний үзүүлэлт	Шатах процессийн онцлого
Шаталт	<ul style="list-style-type: none"> <li>Нүүрсний өсөлтийг авчар байх тусам тэр хэрээр яндар төмөрлөгт шаталт өсдөг</li> <li>Нүүрсний дэгдэмхий хэсэг их байх тусам асалт болон шаталт сайн явагддаг. Гэхдээ ялгар өслтийг тохируулахгүй бол нүүрсний давхархай үүсдэг</li> </ul>
NOx- нилгарал	<ul style="list-style-type: none"> <li>Н ж хольц их байхын хэрээр NOx-н ялгарал ихэсдэг</li> </ul>
Чийг	<ul style="list-style-type: none"> <li>Чийг бууран дэгдэмхий дараа шаталт явагддаг</li> <li>Чийгийн ууршилтаас үүдэн шаталтын температур буурдаг</li> </ul>
SOx- нилгарал	<ul style="list-style-type: none"> <li>Нүүрсэн дэх хүчрийн агуулгын өндөр байх тусам SOx ихээр ялгардаг</li> </ul>
Тоос	<ul style="list-style-type: none"> <li>Туслах илтэй нүүрсээс тоос ихээр ялгардаг</li> <li>Алар дуталдсан хэсэгт нэрийн ширхэгтэй дутуу шатсан нүүрс төрөгч ялгардаг</li> </ul>



No.		Кадр	No.	.	Кадр
а3	NPP 5	Галлагаанд тавигдах шаардлага	а4	NPP 6	Бүрэн шаталт явагдахад тавигдах шаардлага

**Нүүрс ба УХЗ**  
**3. Шаталт явагдахад шаарглагдах хүчин зүйлс**

- Туслах түлш (галлагаар эхлүүлэх үед шаталтыг тэтгэх түлш хэрэглэнэ)
- Агаар (Галын хотол дахь хүчилтөрөгч нь шаталтыг тэтгэгч болдог.)
- Температур (Температур бага байх нь шаталт удаан явагдахад нөлөөлнө.)

Дээр дурдсан нөхцөлүүд нь тогтсон ширмээн дасуу явагдах шаардлагатай.

**Нүүрс ба УХЗ**  
**4. Бүрэн шаталт явагдахад тавигдах нөхцөл**

- Агаарын харьцааг тохируулан галын хотолд жигд түгээх  
(Галын хотолд агаар дутагдсанаас болж дутуу шаталт явагддаг. Харин агаарын харьцаа хэт өсвөл шаталтын температур буурдаг.)
- Шаталт явагдах орчны температурыг өндөрт барих  
(Хүйтэн гадаргуунд галын дөл тусахад тоос болон давирхай үүсдэг.)

No.		Кадр	No.	.	Кадр
а5	NPP 7	Хагас битумтай тослог нүүрс болон хүрэн нүүрсний шаталт	а6	NPP 8	СО-н ялгарал

**Нүүрс ба УХЗ**  
**5. Хагас битумтай нүүрс болон хүрэн нүүрсний шаталт**

- ① Хамгийн түрүүнд чийглэг нь ууршдаг.
- ② Ууршилт дэгдсэний дараагаар шаталт эрчимждэг.
- ③ Энэхүү дулаанаар нүүрс төрөгч асч шаталтын процесс аажмаар явагддаг.

- Нүүрсний дэгдэмхий хэсэг шатах үед агаар дутагдал давирхай болон тоос ялгардаг. Нүүрсийг ихээр ачаалах тусам дээрх нөлөөлөл их байдаг.
- Галын хотол дахь нүүрсний үеийн зузааныг жигд тараахгүй бол агаарын урсгал муудаж Нүүрсний зузаан үет хэсэгт төдий чинээний агаар өгөх шаардлагатай болдог ба, ул ширэмн шалгах аюултай.

**Нүүрс ба УХЗ**  
**6. СО-н ялгарал**

Агаар дутагдсан газарт "СО" үүсдэг.

- Ул ширэмнээс өгч буй агаар нүүрсний үеэр жигд нэвтэрч байх шаардлагатай.
- Илүүдэл агаарын харьцааг хэт их нэмвэл галын хотол дахь агаар дутагдал багасах боловч агаарын урсгал алдагддаг.
- Нүүрсний үе нь жигд тарагдсан тохиолдолд агаарын урсгал хэвийн явагдана.


No.		Кадр
а7	NPP 9	Нүүрсний онцлогт тохирсон УХЗ-г сонгох

**Нүүрс ба УХЗ**  
**7. УХЗ-г нүүрсний чанарт тохируулан сонгох**

- Бага илчлэгтэй нүүрсэнд зориулагдан хийгдсэн зууханд өндөр илчлэгтэй нүүрс ашиглахад ул ширмийг гэмтээдэг.
- Өндөр илчлэгтэй түлшний зууханд бага илчлэгтэй нүүрс шатаахад тогооны температур хангалттай өсдөггүй учраас шаталтын горим алдагдаж (тоос болон давирхай) үүсдэг. Мөн нүүрсний зарцуулалт ихэсдэг тул ул ширмээр нэвтрэх агаарын урсгал мууддаг.

**С. УХЗ болон халаалтын системийн талаар**

<b>No.</b>		<b>Кадр</b>	<b>No.</b>		<b>Кадр</b>
14	PP12	Гарчиг	15	PP13	УХЗ-ны загвар




<b>No.</b>		<b>Кадр</b>	<b>No.</b>		<b>Кадр</b>
16	NPP10	УХЗ-ны шатгалтын тоноглол	17	PP15	УХЗ-ны салхилуурын тоноглол



<b>No.</b>		<b>Кадр</b>	<b>No.</b>		<b>Кадр</b>
18	PP16	УХЗ-ны дулаан хангамжийн усны системийн тоноглол	19	PP17	УХЗ-ны дулааныг дахин ашиглах




No.		Кадр	No.	.	Кадр
20	PP18	АХ-ын бүтэц	21	PP19	УХЗ-ны шүүлтүүрийн тоноглол




**УХЗ-ны үнс баригч төхөөрөмж**

- ◆ Циклон
- ◆ Скрубер
- ◆ Уутан үнс баригч

No.		Кадр	No.	.	Кадр
22	PP20	Циклон	23	PP21	Циклон болон АХ



No.		Кадр	No.	.	Кадр
24	PP22	Скруббер	25	PP23	Скруббер





<b>Но.</b>		<b>Кадр</b>
<b>26</b>	PP24	Уутан шүүлтүүр




<b>Но.</b>		<b>Кадр</b>	<b>Но.</b>	.	<b>Кадр</b>
<b>b1</b>	NPP11	Ялтсан дулаан солилцуур	<b>b2</b>	NPP12	Задвичка /хаалт/



<b>Но.</b>		<b>Кадр</b>	<b>Но.</b>	.	<b>Кадр</b>
<b>b3</b>	NPP13	Задвичка /хаалт/	<b>b4</b>	NPP14	Нэг урсгалт хаалт /Үл буцаах хаалт/



No.		Кадр	No.	.	Кадр
b5	NPP15	Зардал тохируулагч хаалт	b6	NPP16	Даралт тохируулагч



No.		Кадр	No.	.	Кадр
b7	NPP17	Бөмбөлгөн хаалт	b8	NPP18	Насос



#### D. УХЗ-ны галалгааны өмнөх бэлтгэл

No.		Кадр	No.	.	Кадр
27	PP25	Гарчиг	28	PP26	УХЗ-ны галалгааны өмнөх бэлтгэл



No.		Кадр	No.		Кадр
29	PP27	УХЗ-ны галалгааны өмнөх бэлтгэл	30	PP28	УХЗ-ны галалгааны өмнөх бэлтгэл



No.		Кадр	No.		Кадр
31	00096	Даралтын хэмжүүрийн үйлчилгээ	32	00097	Даралтын хэмжүүрийн үйлчилгээ



No.		Кадр	No.		Кадр
33	PP29	Темпертурын хэмжүүр	34	00083	Темпертурын хэмжүүр





Но.	Кадр	Но.	Кадр
35	00086 Темпертурын хэмжүүр суурилуулалт	36	00101 Галын хор



Но.	Кадр	Но.	Кадр
37	00102 Элс	38	00104 Тэжээлийн самбар




Но.	Кадр	Но.	Кадр
39	00107 Тэжээлийн самбар	40	00109 Онцгой үеийн дохио





No.	Кадр	No.	Кадр
41	00110 Семинарт оролцсон сертификат болон галлагааны тэмдэглэл	42	PP30 Халаалтын систем



No.	Кадр	No.	Кадр
43	PP31 Даралтын хэмжүүр	44	PP32 Бойлер



No.	Кадр
45	PP33 Насос



**Е. УХЗ-ны ажиллагаа**

No.		Кадр	No.	.	Кадр
46	PP34	Гарчиг	47	00091	Галын хотол



No.		Кадр	No.	.	Кадр
48	00092	Нүүрс цэнэглэлт (нүүрнээс)	49	00094	Нүүрс цэнэглэлт (араас)



No.		Кадр	No.	.	Кадр
50	00090	Шилээгүүрдэх, нүүрс цэнэглэх	51	00084	Зарцуулалтын хэмжүүр



No.	Кадр	No.	Кадр
52	00085 Зарцуулалтын хэмжүүр	53	00087 Халуун усны шугам



No.	Кадр	No.	Кадр
54	00088 Даралтын хэмжүүр	55	00103 Даралтын хэмжүүр



No.	Кадр	No.	Кадр
56	00099 Тэжээлийн усны насос	57	00100 Тэжээлийн усны насос






No.		Кадр	No.	.	Кадр
58	00111	Яндан	59	CR001,2,4,6,7	Карборобот зуухны галлагаа



No.		Кадр	No.	.	Кадр
60	PP35	Цэвэр/Бохир УХЗ	61	PP36	Агааржуулалтын төхөөрөмжтэй УХЗ



No.		Кадр	No.	.	Кадр
62	P1030727	Утааны хийн байдал	63	00020	Зуухны амны гагнаас муудсан





No.		Кадр	No.	.	Кадр
64	PP37	Зуухны амнаас гарч буй цог	65	000024	Нүүрс цэнэглэлт (МУНТ-н орос зуух)



No.		Кадр	No.	.	Кадр
66	000032	Үнс зайлуулах	67	PP38	УХЗ-ны утааны сувагны алдагдал



No.		Кадр	No.	.	Кадр
68	P1030577	Утааны сувагны алдагдал	69	P1030634	Утааны сувагны алдагдал



No.		Кадр	No.	.	Кадр
70	000017	Ширэмлэсэн үнс	71	000014	Үнс



No.		Кадр
72	000023	Нүүрс хадгалах газар



#### Еа. Эвдрэл гэмтлийн бодит жишээ

No.		Кадр	No.	.	Кадр
c1	NPP19	Тэжээлийн усан дахь O2-с үүдэх зэврэлт	c2	NPP20	Нимгэрч цоорсон хоолой




No.	Кадр		No.	Кадр	
с3	NPP21	Хөлдөлтөөс болж хагарсан хаалт	с4	NPP22	Хөлдөлтөөс үүдэн хагарсан хоолой



No.	Кадр	
с5	NPP23	Хоолойн гадаргуун зэврэлт




No.	Кадр		No.	Кадр	
d1	NPP24	Циклон	d2	MU002	Циклоны бөглөрөл (Үнс авч байх үеийн бичлэг)





No.	Кадр		No.	Кадр	
d3	MU003	Циклоны амаар үнс сорж буй бичлэг	d4	MU004	Яндан (өтгөн утаа)



No.	Кадр		No.	Кадр	
d5	MU005	Яндан (утаагүй)	d6	NPP25	Циклон



Циклоны цэвэрлэгээ үйлчилгээний үр дүн (Сайн жишээ)

Циклоны дээд талын хэсэг

Циклоны доод талын хэсэг

Эх биений дотор талын хэсэг (Налуу багатай хэсэгт үнс тогтож үлдэж байна)

25

No.	Кадр		No.	Кадр	
d7	NPP26	Циклон)	d8	NPP27	Циклонд хийх шинэчлэл

Циклоны цэвэрлэгээ үйлчилгээний үр дүн (Үнсний бөглөрөл)

Унагаасан үнс

Циклоны доод талын хэсэг

Эх биений дотор талын хэсэг (Үнс үлдсэн байна)


26





## Б. Дүгнэлт

Но.	Кадр	
73	PP39	まとめ





Appendix2.4-8 Briefing Paper of Training Material for HOB Operator





**УХЗ-ны сургалтын материалын эмхтгэл (нэгтгэсэн)**

		<b>Товч тайлбар</b>
<b>№.</b>	<b>Кадр</b>	
<b>А</b>	<b>Агаарын бохирдлын өнөөгийн төлөв байдал</b>	
1	Гарчиг	
2	Р11-ээс УБ хотыг өндөр дээрээс харуулах	Өвлийн улиралд яндангаас гарах тоосонцор нь хотын агаар мандалд тогтож агаарын бохирдолыг үүсгэдэг. ДЦС-ын яндан болон хөргөх цамхагаас гарах цагаан уур нь хэсэг хоромын дараа дэгдээд алга болдог хэдий ч тунараад үлдэж байгаа нь тоосоцор юм. Энэ утаа манан алга болвол УБ хотын цэлмэг тэнгэрийг эргүүлэн авч ирж чадна. Эдгээр утаа манан нь үүр цүүрээр температур буурахад доош бууж жижиг тоосонцорууд агаар дахь ууртай нэгдэж утаан хөшиг болж өгтөн манан үүсдэг.
3	Р2-ээс УБ хотын дээрээс авах	Өмнө дурьдсан жишээ бол уулын дээрээс харж байсан бөгөөд газар дээрээс харсан ч агаар дахь тоосны тунаралт ямар байдалтай байгааг харж болно.
4	УХЗ	УХЗ-ны яндангаас тоос ялгарч байгаа ба тус бүрдээ ялгарлын хэмжээ бага байж магадгүй хэдий ч олон УХЗ-нуудаас иймэрхүү хэмжээний тоос ялгарвал утаан хөшиг үүсэхэд нөлөөлдөг.
5	УХЗ	
6	「Агаарын бохирдлын шалтгаан」 -ны хүснэгт	Агаар бохирдолыг бий болгож буй яндангаас ялгарах хаягдал утаанаас гадна үнс хаях талбай болон нүүрсний талбайгаас бужигнах тоос, автомашины хаягдал утаа торгогыг хэлэх бөгөөд агаарын бохирдлыг бууруулж цэлмэг тэнгэрийг эргүүлэн авчрахын тулд бүх нийтээрээ идэвх зүтгэл гаргаж агаарын бохирдлын шалтгаан болох бохирдуулагч бодисын ялгарлыг бууруулах шаардлагатай байна.
<b>В</b>	<b>Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй УХЗ-нууд</b>	
7	「УБ хотод үйл ажиллагаа явуулж буй УХЗ-нууд」	2011 оны жилийн эцсийн бүртгэл тооллогын дүнгээс харахад Улаанбаатар хотод 250 кВт-аас дээш хүчин чадалтай усан халаалтын 98 зуухны газар ажиллаж байгаа бөгөөд эдгээр нь 17 төрлийн 198 ширхэг зуух суурилагдсан байна. Эдгээр зуухнуудын голлох төлөөлөлд:
8	Босоо цилиндр УХЗ	Хятад болон дотоодын үйлдвэрий 50 ширхэг 27%
9	НР-18	НР-18 төрлийн зуух 43 ширхэг 23%

10	Carbobot	Carbobot 30 ширхэг 15%
11	BZUI	BZUI 20 ширхэг 11%
12	DZL	DZL болон CSZL 10 ширхэг 5.4%
13	MUKHT	MUKHT 10 ширхэг 5.4%-ийг тус тус эзэлж байсан ба үлдэгдэл 45.6%-ийн 11 төрөл нь бусад орнуудын зуухыг суурьлуулсан байв.
<b>Ва</b>	<b>УХЗ-ны галлагааны талаар</b>	
<b>а 1</b>	Нүүрсний төлөв байдал	Энэхүү хүснэгтэд нүүрсний коксжилтийг ялгаж харуулсан болно. Монголд хагас битумтай тослог нүүрс болон хүрэн нүүрсийг голдуу олборлож үүнийгээ ДЦС-ууд болон УХЗ-нуудад ашигладаг. Нүүрсэнд агуулагдах чийг, үнслэгийн хэмжээ нь их байдгаас 3000 ккал/кг дулаан ялгаруулалттай нүүрсч байдаг.
<b>а 2</b>	Нүүрсний шаталт	Нүүрсний чанарт галлагааг хэрхэн тохируулан явуулах талаар өгүүлнэ. Нүүрсэнд агуулагдах чийг, үнслэгийн найрлага их байх үед зөв галлагааг явуулахгүй бол тортог ихээр ялгардаг.
<b>а 3</b>	Галлагаанд тавигдах шаардлага	Бүрэн шаталт явуулахын тулд галлагаанд шаардлагатай агаар болон шаталт явагдах орчны температурыг зэргийг тодорхой хүрээнд тохируулах шаардлагатай. Эдгээрийн аль нэг нь алдагдсан тохиолдолд бүрэн шаталт явагдахад бэрх болдог.
<b>а 4</b>	Бүрэн шаталт явагдахад тавигдах шаардлага	Илүүдэл агаарын харьцааг тохируулах шаардлагатай. Агаар дутагдсанаас болж дутуу шаталт явагддаг бол илүүдэл агаарын харьцаа ихэссэнээр агаараар хөргөгдсөн шаталтын температурыг буурч бүрэн шаталт явагддаггүй.
<b>а 5</b>	Хагас битумтай тослог нүүрс болон хүрэн нүүрсний шаталт	Галын хотолд нүүрс ачааллахад шатаж буй нүүрснээс дулаан авч нэн түрүүнд нүүрсний чийг нь ууршдаг. Чийг ууршиж байх явцад нүүрсний гадаргуун хэм нь 100 градус орчим болдог. Ууршилт явагдаж дууссаны дараагаар дэгдэмхий хэсгүүд нь ялгарч энэ нь агаартай нэгдсэнээр эрчимтэй шатдаг. Энэхүү дулаанаар нүүрс төрөгч халж аажим аажмаар шаталт явагддаг. Нүүрсний дэгдэмхий хэсгүүд шатах үед галлагаа хэсэгхэн хугацаанд хурдацтай идэвхиждэг бөгөөд энэ үед агаар дутагдсанаас болж давирхай болон тортог үүсч бий болдог. Галын хотолд нүүрсийг их хэмжээгээр буюу бөөнөөр нь ачааллахад энэхүү үзэгдэл илүү тод илэрдэг. Галын хотол дахь нүүрсний зузааныг нэгэн жигд тараагаагүйгээс болж нүүрсний зузаан давхрагатай хэсэгт агаарын урсгал муудаж агаар дутагддаг.
<b>а 6</b>	СО-н ялгарал	Ул ширэмнээс өгч буй агаар нүүрсний давхрагаар жигд нэвтрээгүйгээс болж агаар дутагдсан газарт СО бий болдог. Ямарч тохиолдолд галын хотол дахь агаарыг дутагдахаас сэргийлж илүүдэл агаарын харьцааг хамгийн байж болох хэмжээнд өгөх арга байдаг боловч агаарын урсгалын нэвчилт муу газарт энэхүү аргыг хэрэглэсэнч үр дүн багаатай тул

	галын хотолд нүүрсний давхаргыг нэгэн жигд зузаанаар тарааж хийх нь хамгийн оновчтой юм. УХЗ-г түүнд ашиглах нүүрсний чанарт тохируулан төлөвлөх. Бага илчлэгтэй нүүрсэнд зориулагдан угсрагдсан УХЗ-нд өндөр илчлэгтэй нүүрс галлахад галын хотлын температур хэт өсч энэ нь ул ширэм зэргийг гэмтээх тохиолдол гардаг. Эсрэгээрээ өндөр илчлэгтэй зууханд бага илчлэгтэй нүүрсээр галлахад галын хотлын температур хангалттай өсдөггүй тул /тортог, давирхай/ ялгардаг. Энэ тохиолдолд галын хотолд ачааллах нүүрсний зарцуулалт ихэсдэг тул ул ширмээр нэвтрэх агаарын урсгал багасч дутуу шаталт явагдах тохиолдол гардаг. Мөн том ширхэглэлтэй нүүрсний зориулалтаар бүтээгдсэн зууханд буталсан нүүрс ашиглавал ул ширэмний нүхээр доош унаж, ул ширэмний нүхийг бөглөх зэргээс үүдэн шаталтын процесс доголдог.
<b>С</b>	<b>УХЗ болон халаалтын системийн талаар</b>
<b>14</b>	Гарчиг УХЗ болон халаалтын системийн тухай танилцуулга
<b>15</b>	УХЗ-ны загвар УХЗ-ны тогооны бүтэц болон шаталтын тоноглол, салхилуурын тоноглол зэргээс хамаарах олон төрлийн загварууд байдаг.
<b>16</b>	УХЗ-ны шаталтын тоноглол Нүүрс шатаах ул ширэм нь үл хөдлөх болон хөдөлгөөнт гэж байх ба хөдөлгөөнт ул ширэмний тухайд автоматаар нүүрсээ өгдөг. Үл хөдлөх ул ширэм нь нүүрс цэнэглэх үнс гаргах арга барилаас хамаарч шаталтын төлөв байдалд өөрчлөлт орж дутуу шаталт болон тоосны хэмжээнд нөлөөлдөг учраас галчийн ажлын ур чадвар ихээхэн нөлөөлдөг.
<b>17</b>	УХЗ-ны салхилуурын тоноглол УХЗ-ны салхилуурын өгөх арга болгож яндангийн соролтын хүчний үйлчлэлтэй ердийн салхилуур, гал тэтгэх агаарыг үлээх салхилуурын сэнс, галын хотлын сийрэгжилтийг агаарын даралтаас бага зэрэг хасах байхаар тохируулж галын хотлын дотроос бургиж үлээхгүй байхаар ажиллуулах утаа сорогч үлээх салхилуурт болон тэнвэржүүлсэн салхилуур байдаг. Шүүлтүүр суурилуулсан УХЗ-ны тухайд шүүх төхөөрөмжөөс болж сийрэгжилтийн алдагдал гардаг тул зөвхөн яндангийн соролтоор бол галын хотлын даралт нэмэх болчих гээд байдаг тул үүнээс сэргийлэх үүднээс утаа сорогч үлээгч салхилуур суурилуулдаг.
<b>18</b>	УХЗ-ны дулаан хангамжийн усны системийн тоноглол Дулаан хангамжийн усыг халаах аргачлалд УХЗ-наас шууд болон ялтсан бойлоороор халаах арга байдаг. УХЗ-наас шууд халаах аргачлалын тухайд температур багатай системийн ус УХЗ-ны дотор дамжих тул экономикайзерын металл температур шүүдэр буух цэгийн температураас бага болж хоолойн гадарга нь хүхрийн хүчилгээс болж зэврэлт үүсдэг.

		Шүүдэрлэх цэг гэдэг нь нүүрс шагахад нүүрсний найрлага дахь хүхэр SO3 болж, утааны хийн температур буурахад утааны хийн дэх чийгтэй нэгдэж хүхрийн хүчил үүсэх температурыг хэлдэг.
19	УХЗ-ны дулааныг дахин ашиглах	УХЗ-наас гарах утааны хийн дулаан энергийг агаар халаагчид өгөх замаар эргэлдүүлснээр зуухны бүтээмжийг хэдэн хувиар нэмэгдүүлж чаддаг. Мөн галын хотол руу орох агаарын температур өндөр болох учраас шаталтын АУК ч мөн өсдөг.
20	АХ-ын бүтэц	Агаар халаагч нь багц хоолойноос бүрдсэн байх бөгөөд хоолойн дундуур шаталтын хий урдаг болон гадна талаар нь шаталтын хий урдаг гэж 2 ангилдаг.
21	УХЗ-ны шүүлтүүрийн тоноглол	УХЗ-ны үнс баригчийн тоноглол болгож циклон, скруббер, уутан шүүлтүүр гэж ашиглагдаж байна. УБ хогын УХЗ-ны 28%-д үнс баригч суурилагдсан байгаагийн ихэнх нь циклон байх бөгөөд скруббер болон уутан шүүлтүүр тоотой хэдхэн байна.
22	Циклон	Утааны хийн доторх тоос нь циклонд төвөөс зугатах хүчний үйлчлэлээр шүүгддэг. Циклоны хэлбэрээс шалтгаалж шүүлтгийн бүтээмж өөр өөр байх бөгөөд ерөнхийдөө 60%-иас дээш шүүлтгийн бүтээмжтэй байдаг. Жижигхэн бөгөөд хялбархан бүтэцтэй учраас бага овроос том оврын УХЗ-нд өргөн хэрэглэгддэг. Гэхдээ шүүгдэх тоос нь циклоны гадагшуулах ам болон хоолойд хуримтлагдах тохиолдолд шүүлтүүр ажиллахгүй болдог тул тогтмол хугацаанд цэвэрлэгээ хийх шаардлагатай байдаг.
23	Үнс баригч болон АХ	Зүүн тал нь агаар халаагч баруун талд суурилуулсан байгаа нь циклон үнс баригч юм.
24	Скруббер	Срубберээр утааны хийг урсаж усаар шүршээд тоосыг шингээж авах төхөөрөмж юм. Энэхүү норсон үнсийг дахин шүршсэнээр хүхэргүүжүүлэх боломжтой боловч нарийн ширхэгнүүдээс бүрдэх бүрхүүл үүссэх тул зуухны ажиллагаанд энэ талдээр анхаарах хэрэгтэй. Шүүгдэж авсан үнсийг уснаас задлах шаардлагатай байдаг тул төхөөрөмжийн хувьд нарийн төвөгтэй болох учраас голдуу том оврын УХЗ-нуудад ашиглах тохиолдол их байдаг бололтой.
25	Скруббер	Скрубберээр ус цацахад SO3 уусч хүхрийн хүчил болдог тул зэврэлтээс хамгаалах үүднээс хоолойг чулуугаар хийдэг.
26	Уутан шүүлтүүр	Утааны хийг шилэн хөвөн зэрэг дулаан тусгаарлах материал ашигласан филтерээр нэвтрүүлж тоосонцорыг шүүж авах зориулалт бүхий төхөөрөмж юм. Тоосонцорыг 99% шүүх өндөр чадвартай. Үнс их хуримтлагдсанаас болж филтерийн нүхнүүд бөглөрдөг тул тогтсон хугацаанд төхөөрөмжийг гадна талаас нь доргиох юмуу эсвэл эсрэг талаас нь даралттай агаар өгч гадаргуунд наалдсан үнсийг унагаах шаардлагатай байдаг. Нүхнүүд хэт их бөглөрснөөс болж энэхүү

		шүүлүүрийн уут урагдах тохиолдолч гардаг. УХЗ-нд нүүрс цэнэглэсний дараа нүүрсний давирхай ялгардаг бөгөөд хэрэв энэ нь шүүлүүрт очиж нүхнүүдийг бөглөсөн тохиолдолд түүнийг цэвэрлэхэд хүндрэлтэй тул зуухыг үргэлжлүүлэн ажиллуулахад бэрх.
<b>b1</b>	Ялтсан дулаан солилцуур	УХЗ-р үйлдвэрлэсэн халуун усыг түгээх үед дахин халаах зориулалттай дулаан солилцуур юм. Нимгэн хөнгөн цагаан юмуу эсвэл зэвэрдэггүй лист хавганг давхарлаж хийсэн бүтэцтэй бөгөөд ялтаснуудын нэг талын зайгаар халуун ус нөгөө талаар нь дулааны зориулалттай ус эсрэг харилцан урсаж байдаг бөгөөд нимгэн ялтасуудын хооронд дулаан солилцоо явагддаг. Гуурсан хоолой ашигласан дулаан солилцуур байдаг боловч ялтсан бойлер нь хамгийн авсаархан тул УХЗ-нуудад ялтсан дулаан солилцуурыг өргөн ашиглагддаг.
<b>b2</b>	Задвичка /хаалт/	Дугуй диск хэлбэрийн хаалт нь дээш доош хөдөлж урсгалыг нээж, хаах зориулалттай. Хаалтыг дээш нь болгон нээхэд түүн догорх даралт бага байдаг тул голдуу том голчтой дулааны шугам хоолойд өргөн хэрэглэгддэг. Хаалтны гол их бие хоёрын хооронд сальник буюу чигжээс нэмж шахаагүйгээс ус алдагддаг тул тогтсон хугацаанд сальник нэмж шахаж байх шаардлагагүй.
<b>b3</b>	Задвичка /хаалт/	Хаалтны хэл нь ховилд эгц дээрээс буухаар хийгдсэн байдаг. Бусад хаалттай харьцуулахад найдвартай хаалддаг бөгөөд голдуу бага голчтой шугам хоолойд ашиглагддаг.
<b>b4</b>	Үл буцаах клапан (хаалт)	Хаалтны эх биеийн нэг хэсэг нь углуургагай байдаг бөгөөд усыг баруунаас зүүн рүү шахахад углуургагай хэсэг усанд цохигдон нээгддэг ба энэ нь усыг эсрэг чиглэлд урсахгүй байх хийц болдог. Зарим тохиолдолд углуурга гацсанаас болж эсрэг урсгалыг зогсоох боломжгүй болдог тул тогтмол хугацаанд үзлэг оношлогоо хийж байх шаардлагагүй. Энэхүү хаалтыг насосны гаралт дээр угсарч насос зогссон тохиолдолд усыг эргэж сорогдохгүй байлгах зорилгоор ашигладаг. Ус буцаж татагдсан тохиолдолд насосны ажиллагаагаар өндөр даралттай болсон ус нь зогссон насосхы голыг эсрэг эргүүлж хөдөлгүүрийг гэмтээнэ.
<b>b5</b>	Зарцуулалт тохируулагч хаалт	Агаарын даралтыг ашиглан усны зарцуулалтыг тохируулагч хаалт.
<b>b6</b>	Даралт тохируулагч хаалт	Эх биеийг пүршээр дарж усны даралт болон пүршний дарах хүчээр хаалтыг хааж байдаг бөгөөд хэрэв усны даралт багасвал хаалт нээгдэж даралтыг тохируулж байдаг.
<b>b7</b>	Бөмбөлгөн хаалт	Нүхтэй бөмбөлгөн хэлбэртэй хаалт бөгөөд барилуыг эргүүлснээр хаагдаж нээгддэг. Нээж хаах ажиллагаа нь хялбар

		байдагын дээр нээлттэй эсвэл хаалттай байгаа эсэхийг нь бариулны чиглэлээр мэдэх боломжтой, сүүлийн үед өргөн ашиглагдаж байгаа хаалт юм.
<b>h8</b>	Насос	Босоо хэлбэрийн насосны жишээ. Дээд хэсэгт нь могор суурьлуулагдсан бөгөөд голд нь эргэх механизм суулагдсан. Голын эргэх механизм хэсэгт ус нэвтрэхгүй байхаар сальник ашигладаг. Доторх шингэний температур болон даралт өндөр болох тусам түүний хийц нарийн төвөгтэй болдог.
<b>D</b>	<b>УХЗ-ны галалгааны өмнөх бэлтгэл</b>	
<b>27</b>	Гарчиг	
<b>28</b>	УХЗ-ны галалгааны өмнөх бэлтгэл	Халаалтын улирал ойртоход УХЗ-ны галалгааны өмнөх бэлтгэл ажил хийх шаардлагатай. УХЗ-ны эргэн тойрны үзлэг болон төхөөрөмжүүдийг шалгасны дараа зуухны ойр орчмын эмх цэгцтэй байдлыг хангаж, мөн УХЗ-ны хөдөлмөр аюулгүй байдлыг хангах бэлтгэлийг хийнэ.
<b>29</b>		УХЗ-ны ажиллагаанд хамгийн чухал хэмжүүр нь манометр, термометр юм. Манометрийн хувьд зурагт үзүүлсний дагуу суурьлуулна. Манометрийг суурьлуулсан хоолойд тахир холбогч болон гогцоон холбогчидийг хийж өгсөн нь хоолой дахь шингэн нь хэрэв уур байх тохиолдолд уурыг хөргөж ус болгосноор манометрт уур орж хэт халахаас хамгаалах зорилготой хийсэн зүйл юм.
<b>30</b>		Энэ бол манометрийн хийцийн зураг юм. Манометрийн оролт дээр 3 талт хаалт суурьлагдсан байгаа бөгөөд үүнийг хааж нээснээр халуун усны хий авах болон манометрт хуримтлагдсан бохирдсон ус зэргийг гадагшлуулах боломжтой.
<b>31</b>	Даралтын хэмжүүрийн үйлчилгээ	Манометрт хийх үйлчилгээний аргачлалын талаарх тайлбар. Дотор нь бөглөрөл үүсгэсэн зүйлийг гаргах.
<b>32</b>	Даралтын хэмжүүрийн үйлчилгээ	Эхлээд манометрт цэвэр ус шахаж 3 талт хаалтыг эргүүлж, манометр доторх бохирдсон усыг зайлуулна. Даралт 0 болсоны дараа дахин даралт шахаж манометрийн зүү хэвийн ажиллаж буйг шалгана.
<b>33</b>	Температурын хэмжүүр	Энэ бол термометрийн хийцийн зураг юм. Халуун усны шугаманд температур хэмжигчийн бортогийг суурьлуулсан бөгөөд түүнд термометрийг суурьлуулж усны хэмийг хэмжинэ. Шилэн термометр хэрэглэж байгаа тул хагарахаас хамгаалж гэр хийдэг.
<b>34</b>	Температурын хэмжүүр	Термометрийг хоолойнд гол хүргэл сайн суулгаж өгөх шаардлагатай. Термометрийг суурьлуулахын өмнө түүний бортогтонд хог байгаа эсэхийг нягтгаж хэрэв байх тохиолдолд түүнийг цэвэрлэх.

35	Температурын хэмжүүр суурилуулалт	Термометрийг бортогыг цэвэрлэж түүнийг зааврын дагуу зөв суурьлуулсан үеийн зураг.
36	Галын хор	Дараагаар нь осол аваараас урьдчилан сэргийлэх болон аюулгүй байдлыг шалгах. Ямарч үед галын аюул тохиолдлоход бэлэн байх үүднээс галын хор, гидрантыг бэлдсэн байх шаардлагатай. Аваарын гарцын тэмдэглэгээг ойлгогдохоор хийх бөгөөд түүний эргэн тойрныг чөлөөтэй байлгах.
37	Элс	
38	Тэжээлийн самбар	Өндөр хүчдэл ирж байгаа газарт өндөр хүчдэлтэй болохыг анхааруулах тэмдэглэгээ хийх шаардлагатай. Мөн холболт яаж хийгдсэн талаар тодорхой тусгах шаардлагатай.
39	Тэжээлийн самбар	
40	Онцгой үеийн дохио	Осол аваарын үед ( галын аюул болон галч ямар нэгэн гэмтэл бэртэл авсан тохиолдол зэрэгт) эргэн тойронд мэдээллэх зориулалттай аваарын дохионы төхөөрөмж суурьлуулах шаардлагатай.
41	Семинарт оролцсон сертификат болон галлагааны тэмдэглэл	Ээлжийн журнал хөглөх зэргийг ойлгоход хялбар загвараас хийх.
42	Халаалтын систем	Энэ бол халаалтын системийн бүдүүвч зураг юм. 2 зууханд халаагдсан ус нь бойлерт түгээгдэж тэндээс гарсан халуун ус нь насосоор даралт авч зуухруу буцдаг. Бойлероор халаалтын зориулалттай усыг 40°C-г халааж хэрэглэгч талын байгууламж руу түгээдэг. Хэрэглэгчээс буцаж ирсэн ус нь насосоор дамжиж даралт авч бойлерт очих гэсэн циклээр явагддаг. Хэрэглэгчийг хангах дулааныг хангалттай түгээж байхын тулд ашиглаж буй нүүрсэндээ тохирсон УХЗ-г сонгохоос гадна халуун усны хэрэглээг бүх хэрэглэгчид саадгүй түгээж чадахуйц системээр төлөвлөж тооцоолох шаардлагатай. Халаалтын улирлын өмнө эдгээр хоолойнуудад усны алдагдал байгаа эсэхийг шалгаж, мөн хий авдаг. Шугамын хийг дутуу авснаас болж зуух паарлах зэрэг гэмтэл гардаг тул шугамын хийг нарийн сайн авах шаардлагатай.
43	Даралтын хэмжүүр	Өгөх болон буцах усны даралтыг хянадаг. Голд суурьлуулсан манометр. Хүний нүдэнд хялбархан харагдахуйц газрыг сонгож суурьлуулах ёстой.
44	Бойлер	УХЗ-наас гарсан халуун усаар халаалтын зориулалтаар дахин халаах төхөөрөмж юм. Ялтсан хэлбэрийн бойлер нь талбай



		бага ашигладаг тул өргөн хэрэглэгддэг.
45	Насос	Насоор даралтыг нэмэх бөгөөд УХЗ-ны системийн ус болон халаалтын шугамын усыг эргэлдүүлж байдаг.
<b>Е</b>	<b>УХЗ-ны ажиллагаа</b>	
46	Гарчиг	
47	Галын хотол	Том ширхэгтэй нүүрсийг эхэлж хийгээд, түүн дээр нунтаг нүүрс хийвэл илүү сайн галлагааг явуулах боломжтой.
48	Нүүрс цэнэглэлт (нүүрнээс)	Нүүрсийг ул ширмэн дээр ижил зузаанаар жигд тараах шаардлагатай. Нүүрсийг хэт их зузаан тарааснаас агаар нэвтрэлт багасдаг учраас ноцолт муудаж тортог их гардаг.
49	Нүүрс цэнэглэлт (араас)	Хэт их том ширхэгтэй нүүрс муу шатдаг. Тохирсон хэмжээтэй нүүрс, нунтаг нүүрсээр ялгаж байгаа байдал.
50	Шилээгүүрдэх, нүүрс цэнэглэх	Нүүрсний зузааныг бодолцож агаар нэвтрэх боломжийг сайжруулахгүй бол нүүрс шатдаггүй. Цог бургиж, энэ үед шилээгүүрээр хутгахад тортог их гардаг тул анхаарах шаардлагатай. Нүүрсийг шилээгүүрдэх болон нэмж цэнэглэх үед үлээх салхилуурыг түр зогсоосноор тоос бургих болон тортог гаралтыг багасгах боломжтой.
51	Зарцуулалтын хэмжүүр	Зарцуулалтын хэмжүүр нь УХЗ-ны тэжээлийн ус болон халаалтын усны зарцуулалтыг хэмжих зориулалттайгаар суурилуулагддаг. Эдгээрийн аль аль нь тохирсон хэмжээгээр түгээгдэх шаардлагатай байдаг. УХЗ-ны усны зарцуулалт дутагдсанаас болж зуух гэмтэх аюултай байдаг. Халаалтын зориулалттай усны зарцуулалт хэмжээндээ хүрэхгүй байх нөхцөлд хангалттай дулаанаар хангах боломжгүй.
53	Халуун усны шугам	Наана байрласан зарцуулалтын хэмжүүр нь системийн усны хэмжүүр бөгөөд энд ямар нэгэн доголдол илэрэх тохиолдолд шугам хоолойн аль нэг хэсэгт алдагдал гарсан байх магадлалтай тул тэдгээрийг шалгах.
54	Даралтын хэмжүүр	Манометр нь УХЗ-ны хувьд хамгийн чухал хэмжүүр юм. Температурыг байнга хянаж, тенпертур өсөхгүй байх хэмжээнд нүүрсний нэмэлт цэнэглэлтийг тохируулах шаардлагатай. Хэрэв тенпертур буурсан тохиолдолд нүүрс нэмэлт цэнэглэлтийн хэмжээг ихэсгэх бөгөөд дахин тенпертур өсөхгүй байвал шугам хоолойн алдагдал гарсан байх магадлалтай тул нэмэлт усны хэмжээ ихэссэн эсэхийг шалгаж шийдвэр гаргах шаардлагатай.
55	Даралтын хэмжүүр	УХЗ-руу өгөх тэжээлийн ус, халаалтын зориулалттай ус, нөөц усны шугам тус бүрт манометр сууруулагдаж хяналт хийх боломжтой болсон байх.
56	Тэжээлийн усны насос	Тэжээлийн усны насосноос ердийн бус дуу авиа болон чичиргээ гарч байгаа эсэхийг шалгах. Эргэх механизм орчмын эмх
57	Тэжээлийн усны насос	цэгцгэй байдлыг хангаж осол аваараас хамгаалах тал дээр анхаарах хэрэгтэй.

58	Яндан	УХЗ-ыг горимын дагуу ажиллуулбал тоос тортогны хэмжээг бууруулах боломжтой. Яндангаас гарч буй цагаан утаа нь уур юм. Илүүдэл агаарын хувь өндөр байвал утааны хий дэх чийгний харьцаа бага байдаг учраас уур үүсэх процесс нь яндангаас гараад хэсэг хугацааны дараа болдог. ДЦС-н утааны хийн хувьд усан шүүлгүүр бүхий циклон ашиглаж байгаа тул утааны хий дэх чийгний агууламж нь ханасан байдалтай байдаг учраас яндангаас уур гарч буй нь харагддаг.
59	Карборобот зуухны галлагаа	Энэхүү зуухны хувьд автомат ажиллагаатай зуух бөгөөд нүүрс, агаарын зарцуулалт автоматаар явагддаг учраас галчын ажлыг нилээд хөнгөвчилсөн. Мөн нүүрсийг жигд давтамжтай хийдэг учраас галлагаа тогтвортой явагддаг тул агаар бохирдуулагч бодис бага ялгаруулахаар ажиллуулах боломжтой. Зуухны байгууламжид тогтмол цэвэрлэгээ хийдэг тул нилээн эмх цэгцтэй байдаг.
60	Цэвэр/Бохир УХЗ	2 зуухыг харьцуулж үзээрэй. УХЗ-ны эргэн тойрныг цэвэрхэн байлгаснаар аюулгүй байдлыг дээшлүүлэхээс гадна галчийг эрүүл мэндийг хамгаалах хамгийн чухал зүйл юм.
61	Агааржуулалтын төхөөрөмжтэй УХЗ	УХЗ-ны дээд хэсэгт бохир агаарыг сорж зайлуулах зоонт суурилуулж вентилиатороор УХЗ-ны ойр орчимын агааржуулалтыг дээшлүүлж буй жишээ.
62	Утааны хийн байдал	Сайжруулах шаардлагатай гэх жишээ юм. Нүүрс цэнэглэхтэй зэрэгцэн асар өтгөн хар утаа гарч 2 минут орчим болоход шингэрэх боловч 5 минут орчим болоход дахин өтгөн хар утаа гарч энэхүү процесс давтагдаж байгаа. Нүүрсийг нэг удаагийн цэнэглэлтээр их хэмжээгээр хийхэд галыг тэтгэх агаар дутагдсанаас болж өтгөн хар утаа гарч байгаа тул нүүрсний цэнэглэлт дээр анхаарах шаардлагатай юм. Яндан болон утааны суваг үнсээр бөглөрсөн тохиолдолд галын хотол дахь хасах даралт багасдаг.
63	Зуухны амны гагнаас муудсан	Зуухны амны өрлөг нягтруулга муудсанаас орчины агаар галын хотолд орсноор зуухны бүтээмж буурдаг бөгөөд нүүрс зарцуулалт ихэсдэг. Галын хотол дахь нэмэх даралт их байх үед цог гадагш тургих аюултай байдаг.
64	Зуухны амнаас гарч буй цог	Зуухны амны өрлөг нягтруулга муу байх тохиолдолд асар их хэмжээний галын цог тургиж буй зуухыг харуулав. Эргэн тойронд нь нүүрс овоолсон байгаа нь гал гарах аюултай юм. Мөн энэ нь галчийн эрүүл мэндэд ч сайнгүй.
65	Нүүрс цэнэглэлт (МУНТ-н орос зуух)	Энэ зуух нь сорох вентилиатортой бөгөөд зуухан доторх хасах даралтаар ажилладаг бөгөөд нүүрс цэнэглэсэн үед нунтаг нүүрс нь огцом шатаж зуухан доторх нэмэх даралтыг үүсгэдэг тул галын цог гадагш цацагдах аюултай тул анхаарах хэрэгтэй.
66	Үнс зайлуулах	Зуухнаас гаргасан шлак нь шатаж дуусаагүй байдалтай байдаг. Шатаж бүрэн дуусаагүй шлактай хамт дутуу шатсан

		нүүрсийг гаргаж, дахин дахин нүүрс цэнэглэдэгээ болж зуухны хүчин чадлаас давсан байдлаар ажиллуулж байгаа гэж бодогддог. Иймэрхүү галлагаа нь мэдээж зуухны бүтээжинд муугаар нөлөөлнө. Улаанаараа шатаж буй шлакыг гаргаад тэр чигт нь орхиод явчихдаг. Яг энэ үед эргэн тойронд нь нүүрс байгаа нь гал гарах магадлал өндөр юм.
<b>67</b>	УХЗ-ны утааны сувагны алдагдал	Энэ бол чулуун утааны суваг бөгөөд зай завсраар нь агаар аллагдсанаас болж яндангийн соролт үр дүнтэй ажиллахгүй болдог. Үүнээс болж галын хотлын сийрэгжилт ихэсч зуухны байгууламжинд шатсан хий цацагдах шалтгаан болдог.
<b>68</b>	Утааны сувагны алдагдал	
<b>69</b>	Утааны сувагны алдагдал	Энэ метал хийцийн суваг бөгөөд зэврэлтээс үүдэн нүх гарсан жишээг харуулсан байна. Энэ тохиолдолд нүхээр хүйтэн агаар сорох, шаталтаас үүдэлтэй хорт хий ялгарах аюултай юм.
<b>70</b>	Ширэмлэсэн үнс	Ширэмлэсэн үнсийг гаргасаны дараач шаталт явагдаж байдаг бөгөөд үүнийг ус шүрших зэргээр унтраахгүй бол дутуу унтарч цогшсон утаа нь агаарт тархаж агаарын бохирдлын шалтгаан болдог.
<b>71</b>	Үнс	Үнсийг гадна овоолсноос үүдэн эргэн тойрондоо дэгдэн хийсдэг тул ус цацах болон хамгаалалт хийх зэрэг арга хэмжээ авах шаардлагатай.
<b>72</b>	Нүүрс хадгалах газар	Булдозер зэргээр нүүрсийг түрэхэд тоосонцор босдог тул эргэн тойронг хашаагаар хаших юмуу ус цацах зэрэг арга хэмжээг авах шаардлагатай.
<b>c1</b>	Тэжээлийн усан дахь O2-с үүдэх зэврэлт	УХЗ-ны үүсвэр усанд энгийн ундны ус ашиглагддаг бөгөөд энэхүү усанд маш их хэмжээний хүчил төрөгч агуулагдаж байдаг. Энэхүү хүчилтөрөгч нь температур өсөхөд ялгарч халаах гадаргуун хоолой болон системийн шугам хоолойн төмрийг исэлдүүлж зэврүүлдэг. Энэ бол исэлдүүлэлтээс үүдэн зэвэрч нимгэрсэн хоолой болон хаалт юм. Ийнхүү исэлдсэн төмөр нь гараар хүрэхэд эвдрэх хэмжээнд баг бөх чанараа алддаг учраас удаан хугацаанд ашиглахад хоолойн хананы зузаан нимгэрч тэсвэрлэх чадваргүй болдог тул солих шаардлагатай болдог. Гүний ус болон голын ус зэрэг нь Ca, Si зэрэг эрдэс ихээр агуулж байдаг учраас хоолойн дотор хананд нэгдэж бөглөрөл үүсгэж зуухны усны эргэлт зогсох гол шалтгаан болдог. Тэжээлийн усны чанарт хяналт тавих асуудал нь УХЗ-ны ажиллагааны хяналтын маш чухал зүйл юм.
<b>c2</b>	Нимгэрч цоорсон хоолой	Нимгэрч цоорсон хоолойн дүр зураг.
<b>c3</b>	Хөлдөлтөөс болж	Өвлийн улиралд УХЗ-ыг түр зогсоосон үед шугам хоолойн усыг бүрэн юүлээгүйгээс үүдсэн ус хөлдөж хаалт болон

	хагарсан хаалт	шугам хоолой гэмтэж эвлэрдэг. Зуухыг түр зогсоох үед халах гадаргууны усыг бүрэн юүлэх юмуу эсвэл энэ нь болмжгүй тохиолдолд тодорхой хэмжээнд усыг эргэлдүүлж хөлдөөхгүй байх арга хэмжээ авах шаардлагатай. Энэ бол хөлдөлтөөс болж хагасран хаалтны зураг.
<b>c4</b>	Хөлдөлтөөс үүдэн хагарсан шугам хоолой.	Хөлдөлтөөс үүдэн хагарсан шугам хоолой.
<b>c5</b>	Хоолойн гадаргуун зэврэлт	Дулааны шугам хоолойн гадаргууг дулаалгын материалаар ороодог боловч тэрхүү дулаалгын материал нь агаар дахь чийгийг шингэсэнээр хоолойн гадаргуу зэвддэг. Халуун уур зэрэг нь өндөр температурагтай байдаг тул дулаалгын материалын сорсон чийгийг ууршуулдаг учраас асуудал гардаггүй боловч бага температурагтай халуун ус түгээх тохиолдолд үүн дээр анхаарах шаардлагатай. Дулаалгын материалын гүйцэтгэлд гаднаас ус чийг нэвтрэхгүй байхаар гүйцэтгэх ёстой. Мөн шугам хоолойн гадаргуунд зэврэлтээс хамгаалах түрхлэг хийж өгөх шаардлагатай.
<b>d1</b>	Циклон үнс баригч	Үнс баригчийн зүүн талд үзүүлсэнтэй ижил төрлийн циклон секцүүд хэд хэдээрээ суурьлуулагдсан байдаг.
<b>d2</b>	Циклон үнс баригчийн бөглөрөл (Үнс авч байх үеийн бичлэг)	Үнс баригчийн ялгаж авсан хуурай үнсийг өдөр бүр цэвэрлэж байхгүй бол бөглөрөл үүсч циклоны шүүх чадвар мууддаг. Циклон секцүүд дээр бөглөрөл үүсэхэд шүүж авсан үнс утааны хийн урсгалын нөлөөгөөр яндангаар гарчихдаг тул циклон бүрэн шүүж чаддаггүй. Шүүсэн үнсний хэмжээ ердийнхөөс бага байвал циклонд ямар нэгэн байдлаар бөглөрөл үүссэн байх магадлалтай юм.
<b>d3</b>	Циклон үнс баригчийн амаар үнс сорж буй бичлэг	Зуух ажиллаж байх үед циклон дотор хасах даралттай байдаг. Циклоны доод талын тагыг нээхэд шүүж авсан хуурай үнс нь доош унах боловч нэг хэсэг нь сорогдон яндангаар гарчихдаг. Доод талын тагыг нээж түүнд шүүж авсан хуурай үнсийг ойртуулахад дүрс бичлэгт үзүүлсний дагуу агшин зуурт сорогдож байна.
<b>d4</b>	Яндан (өтгөн утаа)	Циклон үнс баригч дахь хуурай үнсийг цэвэрлэж дууссаны дараа түүний тагыг сайтар хаахгүй бол шүүж авсан үнс тэр чигээрээ яндангаар гарч байгааг дүрс бичлэгт харууллаа.
<b>d5</b>	Яндан (утаагүй)	Тагыг бүрэн хаасан үед циклон сайн шүүж, яндангаар гарах утааны өнгө ч ийм цэвэрхэн болсон байна.
<b>d6</b>	60 дугаар сургууль	Циклон үнс баригч нь сайн ажиллаж байгаа эсэхийг нягтлах зорилгоор эх биеийг зүсэж үзлэг үйлчилгээ хийсэн. Энэ бол өдөр бүр үнсээ унагааж цэвэрлэж байсан циклон үнс баригч. Үнс баригчийн дотор тал болон доод хэсэгт үнс тоосгүй маш цэвэрхэн байна.



		Дотор талын хацар тал дээрх үнс ерөнхийдөө цэвэрлэгдсэн байсан бөгөөд налуу багагай гадагууны хэсэгт бага зэрэг үлдсэн байна.
 - Дотор байршилд хоолойны хавхлага, фланци г.мэтийн тухайд урьд нь хийсэн байгаа дулаан барих цамц ( фотогоор үзүүлсэн ) -ийг сайжруулан хэрэглэх нь үр дүнтэй.



Зураг 2-1-2. Хоолойн гадаргуу дээрхи хэмийн хавхлагын хэмжээ



Зураг 2-1-3. Дулаан баригч цамц

**2-1-7. Уур ус ялгагч Steam trap-ийг засварласнаар эрчим хүч хэмнэх**

**Хүснэгт 2-1-2. Бүх төрлийн уур ус ялгагч төхөөрөмж steam trap-ийн ажиллах зарчим (1)**

Төрөл	Механик хэлбэрийн			Термо-Динамик Type
	Free Float Type	Lever Float type	Inverted Bucket Type	Диск хэлбэрийн
Зураг				
Ажиллах зарчим	Уур ус ялгагч төхөөрөмжид орсон конденсацлагдсан ус нь хөвүүр бөмбөлөгийг доош нь хөвүүлж, Valve seat ба хөвүүр бөмбөлөгийн хоорондох зайгаар конденсацлагдсан усыг гадагшуулан гаргана. Конденсацилагдсан ус гадагш гарч хөвүүр бөмбөлөг дооцшилоор valve seat-д сууж өгөхөд конденсацлагдсан усны ялгаралт зогсоно. Энэ нь давтагдана.	Уур ус ялгагч төхөөрөмжид орж ирсэн конденсацлагдсан ус нь хөвүүр бөмбөлөгийг доош хөвүүлж, бөмбөлөгтэй хөвүүргээр холбогдсон хавхлага нээгдэж, конденсацлагдсан усыг гадагшуулна. Конденсацилагдсан ус гадагшилж, хөвүүр бөмбөлөг дооцсон хавхлага хаагдахад конденсацлагдсан усны гадагш ялгаралт зогсоно. Энэ нь давтагдана.	Конденсацилагдсан ус дууриад цилиндр дооноос, цилиндртэй нэвчлүүрт холбогдсон хавхлага нээгдэн, конденсацлагдсан ус гадагшилна. Түүний дараа уур усны Bucket дотор орсон, давыг нээж хүү үйлчлэх, bucket-ийг дахиу тулган хавхлага нээгдэн, конденсацлагдсан усны гадагшилалт зогсоно. Түүний дараа Bucket дотор уур нь, кутлак сууцгаар (Bleed hole) орох дамжин гадагш ялгарна. Үүний өнцөг нь дахиу нээж хүү авчнаар алдагдах, нэгдэн конденсацлагдсан ус гадагшилна. Энэ нь давтагдана.	Өндөр хүчтэй уурын урсгал нь дискний доод гадаргыг нам даралтад, дахин уусгагдсан уур нь дискний доод Stem-ийг өгөж авчлалт нээдэг. Тиймээс уур нь уур ус ялгагч төхөөрөмжид хүрэхэд дискийг дотор буулгаж хүү үйлчлэх, диск нь шийтгийн гадаргууд цагдахад, урсгал нь зогсдог. Түүний дараа дулааны тархалтаас шалтгаанан steam-ийн доод даралт уужиж, диск өргөгдөн уурын ус гадагшилна. Энэ нь давтагддаг.

**Хүснэгт 2-1-3. Бүх төрлийн уур ус ялгагч төхөөрөмж Steam trap-ийн ажиллах зарчим(2)**

Төрөл	Bellovs Type	Bi-Metal Type	Balance Pressure Type
	Сильфон хэлбэрийн		
Зураг			
Ажиллах зарчим	Bellovs-ийн тохиргооны температурт хүрэхэд Bellovs нь сунаж, Bellovs-д холбогдсон хавхлагыг хааж, конденсацлагдсан усны ялгаралтыг зогсоодог. Түүний дараагаар дулаан тархалтаар температур буурахад Bellovs агшиж, конденсацлагдсан усыг гадагшуулдаг. Энэ нь давтагдана.	Bi-Metal-ийн тохиргооны температурт хүрэхэд Bi-Metal нь сунаж, Bi-Metal-д холбогдсон хавхлагыг хааж, конденсацлагдсан усны ялгаралтыг зогсоодог. Түүний дараагаар дулаан тархалтаар температур буурахад Bi-Metal агшиж, конденсацлагдсан усыг гадагшуулдаг. Энэ нь давтагдана.	Термо capsule-ийн тохиргооны температурт хүрэхэд Termo Capsule-ийн дотор даралт өндөрж, thermo capsule зөвж томрон, thermo capsule-д холбогдсон хавхлага хаагданаар конденсацлагдсан усны ялгаралт зогсоно. Түүний дараагаар дулаан тархалтаар температур буурахад, thermo capsule агшиж хавхлага нээгдэж, конденсацлагдсан ус гадагшилна. Энэ нь давтагдана.

**Хүснэгт 2-1-4 Уур ус ялгагч төхөөрөмж Steam trap-ийг сонгох хүснэгт**

Тохирох : ○ - △ - × ; Тохирохгүй

Байршуулах газар	Төрөл	Конц/ус	Mechanical Type		Термо-Динамик Type	Температур тохируулагч хэлбэрийн		
			Ball Float	Inverted Bucket	Диск	Bellovs	Bi-Metal	Balance Pressure
Хоолойн системд		Бага хэмжээтэй	×	×	○	×	○	○
		Их хэмжээтэй	○	○	△	×	×	×
Steam Trap (шаардлагатай цэг)		Бага хэмжээтэй	×	×	○	×	×	×
Steam Trap (ердийн цэг)		Бага хэмжээтэй	×	×	○	×	○	○
Дулаан солигдуур, хатаагч, бусад гадна		Бага хэмжээтэй	○	○	×	×	○	○
		Их хэмжээтэй	○	△	×	×	×	×
Уурын усыг буцаан цуглуулах		Бага хэмжээтэй	○	○	×	×	○	○
		Их хэмжээтэй	○	○	×	×	×	×
Дулааны зориулалттай радиатор		Бага хэмжээтэй	△	△	△	○	○	○
		Их хэмжээтэй	○	○	×	×	×	×

**Уур ус ялгагч төхөөрөмж (Steam trap)-д шаардлагатай байгаа засварыг хийснээр гарах үр дүн**

Тохирсон засвар арчилгаа хийдэггүй байгаа тохиолдолд Steam trap-ийн бүтээмж : 15 - 30% бууралттай байдаг.

Бүх уур ус ялгагч төхөөрөмжид жилд ( 2 эсвэл 1 удаа ) үзлэг шалгалт хийх  
 - Уур ус ялгагчийн жагсаалтыг гаргаж доголдолгүй ажиллагаатай байлгаж асуудалд анхарвалхас гадна үзлэгийн бүртгэлийг хөтлөх.  
 - Үзлэг шалгалтыг үр дүнтэй аргачлалаар явуулах.  
 - Үр дүнг нягтлан тоон үзүүлэлтээр илэрхийлэх.  
 \*Доголдолтой байгаа дараа уур ус ялгагч төхөөрөмжийг засварлах, солих  
 ○ Дотоод хэсгийн алдагдлаас шалтгаалж уурын алдагдаж байгаа тохиолдолд  
 ○ Бөглөрөл үүссэн  
 ○ Chattering (Диск хэлбэрийнх дээр) Нээгдэх, хаагдах процесс нэг дор давтагдаж байгаа тохиолдолд  
 ○ Уур ус ялгагч их биеийн гадна хэсгээс алдагдалтай байгаа тохиолдолд ( хоолойнаас алдагдаж байгаа тохиолдолыг мөн хамруулна )

Тохирсон засварыг нь хийсэн тохиолдолд уур ус ялгагч төхөөрөмжийн бүтээмжийн доголдол 5 хувиас бага болно.

**Уур ус ялгагч төхөөрөмж Steam trap үзлэг шалгалт хийх аргачлал**

«Хүний 5 мэдрэхүйд тулгуурласан арга»

- 1) Харааны : Уурын алдагдал
- 2) Сонголын: Хэвийн бус дуу чимээ, хэвийн бус чичиргээ

«Багаж ашиглан хийх үзлэг шалгалт»

- 1) Сонох багаж Сонох багажийг ашиглан уур ус ялгагч төхөөрөмж хэвийн ажиллаж байгаа эсэхийг оношлох. Мөн хэвийн бус байдлыг илрүүлнэ.

- 2) Гадаргуун температурыг хэмжигч
  - Tempo scale гадаргуун дулаан хэмжигч
  - Хэт ягаан туяаны цацрагаар температур хэмжигч


Уур ус ялгагч төхөөрөмжийн ойр орчмын гадаргуун хэмийг хэмжигч, steam trap-т ямар нэг доголдол байгаа үгүйг оношлоно.

- 3) Уур ус ялгагч төхөөрөмжийг шалгалч - Steam trap checker Уур ус ялгагч төхөөрөмжийг шалгалч -Steam trap checker нь чичиргээний уузуултээр автоматаар уур ус ялгагч төхөөрөмжийн хэвийн ажиллагаатай байгаа эсэхийг оношлон сайдуу уурын аргаар хэмжээг ч мөн тогтоодог. Хяналтын хүснэгтийг гаргадаг функцтэй ч мөн байх ба team trap-ийн хяналтад маш үр дүнтэй.




**2-2. Эйр компрессор дээрх эрчим хүч хэмнэлт**

**2-2-1. Эйр компрессорын төрөл**



**2-2-2. Эйр компрессорын эрчим хүч хэмнэлтэд анхаарах зүйл**



**2-2.3. Эйр компрессорын гаргалтын даралтын бууруулснаар хэмнэх эрчим хүч**

Эйр компрессорын агаар нягтруулагчийн гаргалтын даралтыг бууруулснаар зарцуулах хүчийг багасгах боломжтой. 0.1MPa-ийн даралтыг бууруулснаар ойролцоогоор зарцуулах хүчийг 8%-аар хэмнэнэ.




График2-2-1 Гаргалтын даралт ба зарцуулагдах хүчний харьцаа

**2-2-4. Эйр компрессорын соролтын агаарын температурыг бууруулснаар хэмнэх эрчим хүч**

Агаар нягтруулагч төхөөрөмжийн соролтын агаарын хувийн жин ихсэх учраас зарцуулагдах эрчим хүчийг хэмнэх боломжтой.





График 2-2-2 Соролтын агаарын хэм болон зарцуулагдах хүчний хувийн хамаарал

### 2-2-5. Нягтруулсан агаарын алдагдлыг багасгаснаар хэмнэх эрчим хүч

1) Алдагдаж буй хэмжээг урьдчилан тогтоох  
 Хоолойны нээх хэсгээс алдагддаг нягтруулсан агаарын алдагдлын талаар график болон хүснэгтэд үзүүлэв.



Зургаар 2-2-3-ийн үндсэн диаметртэй адилтгах буй дугуйн хэмжээний хэмжээг харуулахад. Зургаар 2-2-1-ийн сонгох хэмжээгээр агаарын алдагдлыг багасгах боломжтой.

2) Нягтруулсан агаарын алдагдлаас шалтгаалсан эрчим хүчний алдагдал  
 Тухайн компрессороос шалтгаалан ялгаатай байх боловч 0,7MPaG 1Nm<sup>3</sup> нягтруулсан агаар гаргахын тулд шаардлагатай хүч (цахилгааны хүч) нь 0.1kWh орчим байдаг.

Түүнчлэн, 1mmφ-бүхий сүвээр агаар алдагдал гарч буй (сийгэх чимээ бага түвшинд) тохиолдолд ойролцоогоор 4Nm<sup>3</sup>/h байгаа учраас 0.5kW-ийн цахилгааны алдагдал гарч байна гэсэн үг.

Оношлох	Шинж байдал	Алдагдаж буй хэмжээг тооцоолох Nm <sup>3</sup> /h
30 ~ 50см-ийн зайнаас нүдээр харваад нягтлах боломжтой.	Үл мэдэг сийгэх Тасралтгүй сийгэх Хүчтэй сийгэх Сийгэх чимээ бага Сийгэх чимээ Хүчтэй сийгэх чимээ	0.5~1 1~2 2~3 3~5 5~10 10-аас дээш

3) Алдагдаж байгаа хэсгүүдийн үзлэг оношлогооны арга

Дараах аргууд байдаг ба ①-ийн хэт авианы долгионоор алдагдлыг тогтоох төхөөрөмжөөр тогтоох арга нь холын зай дах алдагдлыг ч сайтар илрүүлдэг учраас хамгийн тохиромжтой.



Зургаар 2-2-4-ийн хэт авианаар алдагдлыг илрүүлэх багас.


- ① хэт авианы долгионоор алдагдлыг тогтоох төхөөрөмжөөр тогтоох арга (фотогоор үзүүлэв)
- ② Алдагдаж буйг чимээгээр нь сонсож тогтоох арга
- ③ Савантай ус түрхэж түүний хөөсрөлтөөр тогтоож илрүүлэх



Зургаар 2-2-5-ийн нягтруулсан агаар алдагдаж байгаа хэсэг.

### 2-2-6. VSD компрессор хэрэглэснээр эрчим хүч хэмнэх

Screw компрессорын даралтын асаагуураас шалтгаалах ачаалал/ачаалалгүй ажиллуулалт төхөөрөмж ба inverter төхөөрөмжийн цахилгаан гүйцэл болон даралтын хэмжилтийн өгөгдлүүд 1 тус бүр 1ширхэжгүй ажиллагаагаар ижил өдрөт, ижил цагт хэмжилт хийл.



Screw компрессорын даралтын асаагуураас шалтгаалах ачаалал/ачаалалгүй ажиллуулалт төхөөрөмж ба inverter төхөөрөмжийн цахилгаан гүйцэл болон даралтын хэмжилтийн өгөгдлүүд.

Норматив салхины хэмжээ: 830.4 Nm<sup>3</sup>/h  
 Норматив хүчдэл: 75 kW

Дундаж шалтгаан гүйцэл: 96.9 A  
 Дундаж даралт: 7.42 bar

Screw компрессор VSD

Салхины норматив хэмжээ: 756.0 Nm<sup>3</sup>/h  
 Норматив хүчдэл: 62 kW

Дундаж шалтгаан гүйцэл: 65.3 A  
 Дундаж даралт: 7.21 bar

### Хүснэгт 2-2-2 Onload /Unload төхөөрөмж ба VSD-ийн харьцуулалт

	Цахилгаан гүйдлийн үзүүлэлт (дундаж) A	Даралт (Дундаж) Bar	Тайлбар
Onload/unload төхөөрөмж	96.9 (100%)	7.42	Даралтын асаагуурын тохиргоо - Load~Unload : 7.8 Bar - Unload~Load : 7.0 Bar.
VSD	65.3 (67%)	7.21	Нягтаршуулсан агаарын шаардлагатай минимум даралт нь 7.0 Bar учраас тохиргооны даралтыг дахин багасгах боломжтой. Энэ тохиолдолд цахилгаан гүйдлийн үзүүлэлт (цахилгаан эрчим хүч) ч мөн буурна.

### 2-3. Салхилуурын эрчим хүч хэмнэлт

### 2-3-1. Салхилуурын төрөл

Хүснэгт 2-4-1 Салхилуур төрөл, бүтээмж болон чухал ашиглалт

Төрөл	Бүтээмж (%)	Гол ашиглалт	
Төвөөс зугатах хүчний төрөл	Эсрэг цохилтот салхилуур	70 ~ 80	Ердийн салхилуур
	Турбин салхилуур, хугацаат ачаалалт салхилуур	70 ~ 85	
	Далбаан хэлбэрт салхилуур	75 ~ 85	Өндөр хурдны агаарын хоолойд
	Радиал салхилуур	60 ~ 75	
	Олон далбаачит салхилуур	60 ~ 70	Нам хурдны агаарын хоолой, хэсэгчилсэн цэгийн салхилуур
Тэнцлэг голт төрөл	Хоолойн тэнцлэг голт салхилуур	60 ~ 75	Ердийн салхилуур, хэсэгчилсэн салхилуур
	Тэнцлэгийн салхилуур	60 ~ 75	Том хөргөгч цамхаг, байршлын салхилуур
	Агаар хувиарлагчтай далбаан салхилуур	75 ~ 85	Нам хурдны агаарын хоолой, хэсэгчилсэн, цэгийн салхилуур
	Далбаан салхилуур	50 ~ 60	Бага орон хөргөгч цамхаг, агааржуулагч
	Ташуу хэлбэрт	50 ~ 60	Бага орон хөргөгч цамхаг, агааржуулагч
Бусад	Ташуу урсгалт салхилуур	75 ~ 85	Байршлын салхилуур
	Хуйвруулах урсгалт салхилуур	40 ~ 50	
	Шугаман урсгалт салхилуур ( тангenciал салхилуур, огтлолцсон урсгалт салхилуур )	40 ~ 50	Салхилуурын хөшиг Air curtain Ороомог салхилуурийн холимог



### 2-3-2. Салхилуурын эрчим хүч хэмнэлтийн анхаарах зүйлс


- 1) Ачаалал өөрчлөгдсөн үед тэр өөрчлөлтөнд тохируулан салхилуурын хэмжээг тохируулах аргачлалыг судлаж үзэх.
- 2) Зарцуулагдах хүчдэл нь салхилуурын хэмжээ болон даралтын үржвэрд порпорцлохын тулд процессын хэрэгцээт салхилуурын хэмжээ болон даралтын бууруулах оролдлого хийх.
- 3) Хэт ихэссэн утаа хэрэгцээгүй үеийн ажилуулах зэрэгт станц талд хэрэгцээт салхилуурын хэмжээг зөв цагт нь тохируулах удирдлагын системийг судлаж үзэх.
- 4) Өндөр бүтээмж бүхий станц талын техникийн тодорхойломжид тохирсон онцлог чанар байгаа эсхийг судлаж үзэх.
- 5) Чичирхийлэл, бусад дуу чимээ, гадна бүрхэвч болон далавчинд тоос, сорогдох хоолойны урсгалын туйлшрал нөлөөлснөөс соролт нь муудсан эсэхийг нягтлах.
- 6) Голноос агаар алдаж байгаагаас чанар бүтээмж доошилсон эсэхийг нягтлаж үзэх.

43


### 2-3-3. Салхилуурын эрчим хүч хэмнэлтийн аргачлал

- 1) Салхилуураас өгөх агаар тогтмол үед
  - ① Далавчны гадна диаметрийг хасах ( Насостой адил )
  - ② Бага хүчин чадлын далавч руу шилжүүлэх
  - ③ Олон шатлалт урсгалыг цөөн шатлалд шилжүүлэн хэмнэх
  - ④ Тэнхлэг голт салхилуурын хэмжээг бууруулах ( Угсралтын өнцөгийн өөрчлөлт )
- 2) Салхилуураас өгөх агаарын хэмжээ нь өөрчлөгдөх үед
  - ① Даралт бууруулалтын хяналт
  - ② Соруулах хүрээм хяналт
  - ③ Салхилуурын тоо ширхэгт тавих хяналт
  - ④ Далавчны өнцөгийн өөрчлөлтийн хяналт
  - ⑤ VSD буюу эргэлтийн тоог өөрчлөх ажиллагаат

44



Зураг 2-4-1 Салхины хэмжээн дэх тэнхлэг эргэлтийн хүч



Зураг 2-4-2 Салхилуурын эргэлтийн тоог тохируулах хяналтын жишээ

45

### 2-4. Гэрэлтүүлгийн эрчим хүч хэмнэлт

46

#### 2-4-1. Гэрэлтүүлгийн эрчим хүч хэмнэлтэд анхаарах зүйлс

##### Хэрэгцээгүй гэрэлтүүлгийг унтраах

- Гэрэл хэрэглэх цагийг багасгах
- Өдрийн амралтаар гэрлээ унтраах
- Цонхны гэрэл орох боломжтой хэсгүүдийн гарлиг унтраах
- Хүнгүй газрын гэрлийг унтраах

##### Гэрэлтүүлгийн түвшин болон гэрэлтүүлэх төхөөрөмжийн байрлалыг сайжруулах

- Гэрэлтүүлэлтийн түвшинг тохируулах
- Гэрэлтүүлэлтийн түвшинг судалж өөрчлөлт
- Байгалийн гэрэлтүүлгийг сайжруулах
- Гэрлийн нийцэлтийн тоог цагцлах
- Салбар хэсгийн гэрэлтүүлгийг сонгох

##### Гэрэлтүүлэх төхөөрөмжийн засвар үйлчилгээ

- Тохирох лампаар солих
- Гэрэлтүүлэх төхөөрөмжийг тогтмол цэвэрлэх

##### Гэрэлтүүлэх төхөөрөмжийг цагцлах

- Бүтээмж өндөртэй лампийг сонгох
- Хүчдэл хэмнэдэг төрлийн лампаар солих
- Тусгал сайтай гэрэлтүүлэх төхөөрөмжөөр солих

47


#### 2-4-2. Төлөөлөл болох гэрлийн чийдэнгүүдийн төрөл

##### Хүснэгт 2-4-1 Төрөл болон онцлогууд

	Улайслаг чийдэн	Өдрийн гэрэл ( Улайсдаггүй )	Өдрийн гэрэл ( Бөмбөлөг хэлбэрийн )	HID төрлийн чийдэн
Хэлбэр				
Онцлог	Нийтлэг хэрэглээний ламп	Тойрог болон саваа хэлбэрийн ламп	Улайсдаг лампны оронд оронд өргөн хэрэглэдэг.	Хэмжээ томтой ватт өндөртэй
Зориулалт	Багц гэрэл, угталын өрөө, ариун цэврийн өрөө г.м	Үйлдвэр, контор, зочны өрөө, унтлагын өрөөны гол гэрэлтүүлэгт	Улайсдаг лампны оронд оронд өргөн хэрэглэдэг	Үйлдвэр, спорт зал, авто замд
Бүтээмж	Муу	Сайн	Сайн	Сайн
Хэрэглэгдэх хугацаа	Богино	Урт	Урт	Урт

48

2-4-3. Гэрэлтүүлэгийн зарцуулах хүчдэлийн өөрчлөлт болон хэрэглэгдэх хугацаа



Хүснэгт 2-4-1 Төрөл тус бүрээр нь гэрлийн чийдэнгийн хүчдэл зарцуулалтын өөрчлөлт

Гэрлийн эх үүсвэрийн төрөл	Хэрэглэгдэх нормт хугацааТ
Улайсдаг гэрлийн чийдэн	1,000 – 2,000
Өдрийн гэрэл	6,000 – 8,000
Хоолон өдрийн гэрэл ( HF агуулсан )	12,000
Мөнгөн усан гэрэл	9,000 – 12,000
Металл гэрэл	6,000 – 12,000
Өндөр даралттай натрийн гэрэл	9,000 – 12,000
LED гэрэл	40,000

Хүснэгт 2-4-2 Төрөл тус бүрийн хэрэглэх хугацаа

2-4-4 LED-Гэрэлүүд

LED : Light Emitting Diode



Бөмбөлөг гэрэл



Доошоо шугаман



Цэгэн шугам

Үнэ : Ижил гэрэлтүүлэх хүчин чадал бүхий улайсдаг чийдэнгээс ойролцоогоор 20 дахин

Үнийн хувьд илүү үнэтэй ч, улайсдаг чийдэнгийн гэрэлтэй харьцуулахад 20 дахин илүү хэрэглэгдэх хугацаа урт, цахилгаан зарцуулалт ойролцоогоор 10 дахин бага зэрэг нэлээд ашигтай байна.

«LED гэрлийн онцлог»

Улайсдаг гэрлийн чийдэнтэй харьцуулахад 90% цахилгаан хэрэглээний хэмнэлттэй

Хэрэглэгдэх хугацаа : 40,000 цаг

1) Мөнгөн ус агуулаагүй

4) Нүүрстөрөгчийн хийг 90%-аар бага ялгаруулдаг.

2) Асалт хурдантай

5) Байн байн асааж унтаахад шаталт багатай

3) Шавьж үргээдэг

6) Хэт ягаан туяа багатай, хэт ягаан туяа бага ялгаруулдаг

3 . Япон дахь эрчим хүч хэмнэлтийн арга хэмжээний жишээ

3-1. Эрчим хүч хэмнэлтийн арга хэмжээний жишээ-1

Дулаалгын цамц хийж уурын хоолойн хавхлагын халууныг барих

- Бодит байдал
  - Уурын даралт / Температур: 10.5 bar / 185 °C ( Ханасан уусмал)
  - Хавхлага, фланцанд халуун баригчгүй

- Арга хэмжээ
 

Доорхи уурны толгой хэсгийн хавхлагад дулаан баригч цамц хийж дулаан бариулсан

  - Фланецны бээлий хавхлага (4 инч JIS20K) x 2
  - Фланецны бээлий хавхлага (3 инч JIS20K) x 1
  - Фланецны бээлий хавхлага (2 инч JIS20K) x 1



Өмнө



Дараа

Дулаан баригч цамц

3. Үр дүн
  - 1) Дулаалгагүй хавхлага (4ш)-т дулаан хадгалуулах арга хэмжээ авснаар гарах үр дүнг тооцов.

Хүснэгт 3-1 Дулаалгагүй хавхлаганы гадаргуунаас алдагдах дулааны хэмжээг тогтоож, тооцоолсон үр дүн

Хавхлаганы хэмжээ инч	Орчны температур °C	Гадаргууны температур °C		Алдагдах дулаан kJ/h		Дулаан хадгалсан бүтээмж %	
		Дулаан хадгалалчгүй	Дулаан хадгалалч	Дулаан хадгалалчгүй А	Дулаан хадгалалч В	Бодит (1-В/А)x100	Онол
2	26	185.2	45.5	2,569	210	91.8	90.0
3	26	185.2	45.5	4,455	313	93.0	90.5
4	26	185.2	45.5	5,560	391	93.0	90.7

- Дулаан баригч хийжээс өмнөх дулаан алдагдлын хэмжээ: 18,100 kJ/h
  - Дулаан баригч хийсний дараах дулаан алдагдлын хэмжээ: 1,300 kJ/h
  - Дулаан алдагдлын бууралтын хэмжээ: 16, 800kJ/h
- 2) Зуухны түлшний ( мазут ) хэрэглээний хэмжээний бууралт : 4.0 ton/жил

4. Оруулсан хөрөнгө нөхөн төлөгдөх хугацаа  
Хагас жил дотор
5. Тайлбар  
Өндөр дулааны дулаалгагүй хавхлага, фланец зэрэгт дулаан хадгалалч хийхэд оруулсан хөрөнгө оруулалт нөхөн төлөгдөх хугацаа богино, үр дүн сайтай эрчим хүч хэмнэлтийн арга хэмжээ байлаа.

## Эрчим хүч хэмнэлтийн арга хэмжээ жишээ-2

### Уур ялгагчийн хяналтыг бэхжүүлэх

- Өнөөгийн байдал
  - Тогтмол хугацааны уур ялгагчын үзлэг болон түүний засвар үйлчилгээ хийгдээгүй.
  - Өндөр давтамжит мэдрэгч төхөөрөмж болон доргион мэдрэгчээр савхаар хэсэгчилсэн үзлэг хийхэд, уур ус ялгагч төхөөрөмжийн бүтээмжийн алдагдал 30% байлаа. ( зурагт үзүүлэв )
  - Уур ус ялгагч төхөөрөмжийн тоо : 40ш ( Үүнээс 12 нь доголдолтой ажиллаж байгаа гэж тооцоолж байна. )

- Арга хэмжээ
 

Жилд 1-ээс дээш удаа, тогтмол хугацаанд уур ялгагчид үзлэг хийж шаардлага хангахгүйг солих

- Үр дүн
  - Уур ялгагчийн доголдол буурч : Ойролцоогоор 30% → 5%-аас доош
  - Уурын алдалтын бууралт: Ойролцоогоор 770 ton/year
  - Зуухны түлш ( мазут) хэрэглээний хэмжээний бууралт: 56 ton/жил

- Хөрөнгө оруулалт нөхөн төлөгдөх хугацаа
 

Ойролцоогоор хагас жил ( Эхний жилдээ )

Үзлэгийн савх



Өндөр давтамжит мэдрэгч төхөөрөмж

55

## Эрчим хүч хэмнэлтийн арга хэмжээ жишээ-3

### Баг бүлгийн үйл ажиллагаагаар эрчим хүч хэмнэх "Түлхүүр үг бол хайран"

Nippon Hard Metal Co.LTD  
Кююшюү үйлдвэр

- 2008 оны эрчим хүч хэмнэлтийн шилдэг нэгжээр шалгарсан, түүний бодит жишээ
- QC түүхд үндэслэсэн эрчим хүч хэмнэлтийн үйл ажиллагааны загвар жишээ

56

### Сэдвийн агуулга

Байгууллагын хариуцагын хувьд ISO14001 Байгаль орчны стандартын нөхцлийг зайлшгүй хангаж зөвшөөрөл авсан байх шаардлагатай бөгөөд "Олон бичиг цаас үйлдэж, албан ёсны тоо, туйлширсан удирдлага" гэсэн байдлаар хандвал алдаа гардаг. Иймд эрчим хүч хэмнэлтийн ISO-г авах бэлтгэл үйл ажиллагаа явуулж, удирдлагын хувьд хангалттай бүрэлдсэн байдал шаардлагатай.

### Үйлдвэрийн агуулга

- Бүтээгдэхүүний нэр Хатуу хайлш
- Ажиллагсад 150
- эрчим хүч хэрэглээний хэмжээ Түлшний тос : 848 kl/y  
Хүчдэл : 2,130 Mwh  
Нийт : 1,372 COE kl/y

### Үйл ажиллагааны хугацаа

- Төлөвлөлт төлөвлөгөөг гаргах хугацаа 2005 он 4-н сар 1 өдөр-7-р сар 31 (нийт 4 сар)
- Хэрэгжүүлэх ажиллагааны хугацаа 2006 он 7-н сар 1 өдөр-2006 он 3 сар 31 (нийт 9 сар)
- Үр дүнгийн хяналтын хугацаа 2005 он 8-н сар 1 өдөр 2006 он 7-р сар 31 (Нийт 12 сар)

57


### 1. Сэдэв сонголтын шалтгаан

Агуулгад дурьдсанчлан манай компани нь 2007 оны ISO-н эрхийг авахад чиглэсэн эрчимжүүлсэн бэлтгэл үйл ажиллагааг өрнүүлэх төлөвлөгөөтэй бөгөөд нийт гишүүдийг хамруулсан үйл ажиллагаа болгон зохион байгуулмаар байна. Ухамсарын шинэтгэл хийхийн тулд үр дүнг үзүүлэлтээр тодорхой байдлаар гаргаж танилцуулан тайлагнаж, бодитойгоор эдийн засгийн үр дүнг дээшлүүлж, удирдлагын шатанд үр ашигтай байдлыг мэдрэх.

### 2. Бодит байдлыг тодорхойлох

эрчим хүчин эх үүсвэрийг нэгжээр хянах

Үйлдвэрлэлийн шугам-1 (Нийт өртөгийн үйлдвэрлэлийн шугам) kwh/kg  
Үйлдвэрлэлийн шугам-2 (Нийт өртөгийн зарцуулах шугам) kwh/ширхэг



58

### 3. Үйл ажиллагааны явц

#### 3.1 арга хэмжээний тогтолцоо

Баруун талын зурагт үзүүлэв

#### 3.2 Зорилтоо тогтох

Эхний жилдээ нагжид зарцуулах хувийг 3%-аар бууруулах зорилго тавих

#### 3.3 Асуудлууд болон түүнийг шийдвэрлэх

- Асуудлууд
  - Багууд үйл ажиллагааны туршилта багатай
  - Бодитойгоор сайжруулах ёстой асуудал байгаагүй
  - Тодруулж тэмдэглэсэн өгөгдөлгүй
  - Хэмжээний тоо үзүүлэлт гарч ирээгүй

#### Яаралтай хэрэгжүүлсэн агуулга

- Гол байгууламжуудад хүчдэл хэмийг суурилуулах
- Нийт 35-н байгууламж
- Нийт зардал: 1.6 сая иен


### 4. Үйл ажиллагааны агуулга

- Суурилуулсан хүчдэл хэмийгчээр хүчдлийн зарцуулалтыг тодорхойлох, дүн шинжилгээ хийх
- Хэрэгцээгүй хүчдлийн зарцуулалтыг багасгахын тулд, арга хэмжээ бодлогын 20-н сэдвийг сонгож гаргах
- Ерөнхий хяналтын хүснэгтийг гаргаж ба сэдэв тус бүрийн хариуцагч-төсөв, явцын байдал- үр дүнгийн таамаглал- сайжралт зэргийг ойлгомжтойгоор гаргасан тухайн хүснэгт ийн дагуу үйл ажиллагааг өрнүүлнэ.

59

### 4.4 Арга хэмжээг хэрэгжүүлэх жишээ (1)

Хийн компрессорын ажиллагааны сайжралт



Компрессорын ачааллын муруй (сайжруулахын өмнө)

Компрессорын ачааллын муруй (сайжруулсны дараа)

Арга хэмжээ

Сайжруулах зүйлс

Сайжруулсан үр дүн

- Ням гаргарт компрессор -ыг зогсоох
- Компрессорын ажиллуулах тоог багасгах (2-ыг 1нд)
- Компрессорын даралтын тохируулгыг багасгах (0.7MPa-наас 0.55MPa)

Ажиллах техникийн тоог багасгаснаар хэмнэсэн 8,204 kWh/сар

Хугацаат унтраалга Суулгаснаас хамаарах хэмнэлт 1,792 kWh/сар

Автомат унтраалга

- Компрессорын алдалтыг шалгах болон доголдолтой газрыг засварлах
- Компрессорын хэрэгцээт даралт руу шилжүүлэхдээ Урьдчилан шалгасан байх

Хэмнэсэн хүчдэл: 195Mwh


Хэмнэсэн зардал: 2.5MM¥/y

Хөрөнгө оруулалт эргэн нөхөх хугацаа: 1.0 сар

60

#### 4.4 Арга хэмжээ хэрэгжүүлэх жишээ (2)



Гэрэлтүүлэгийн байршлийг өөрчилснөөр мөн төрлийг өөрчилснөөр цахилгаан хэмнэнэ



Сайжруулах зүйлс	Арга хэмжээ	Сайжруулсан үр дүн
<ul style="list-style-type: none"> <li>Гэрэлтүүлгийн төрөл өөрчлөлт</li> <li>Хэсэгчилэн гэрэлтүүлэх аргачлалыг сонгох (Наланхуйдах гэрэл – хэсэгчилэн гэрэлтүүлэх)</li> <li>Хэсэгчилэн гэрэлтүүлэх байрлал өөрчлөх боломжит байгууламж</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Мөнгөн усан гэрэл – Никель тоглол бүхий айлттой өдрийн гэрэл</li> <li>32-ш мөнгөн усны гэрлийг 53ш өдрийн гэрлээр солих</li> <li>Өдрийн гэрлийн унжуулж буулгахаар, зөвхөөр суурилуулж</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хэмнэсэн хүчдэл: 51MWh/жил</li> <li>Хэмнэсэн өртөг: 665.000/жил</li> <li>Хөрөнгө оруулалтыг эргэн нөхөх хугацаа: 1.3жил</li> </ul>

61

#### 5. Үр дүнгийн магадалгаа



62

#### 6. Дүгнэлт

- Зорилгоо хангалттай биелүүлж чадаж, багийн гишүүд маш их сэтгэл хангалуун байна.
- Энэ ажиллагаа нь амжилттайгаар өрнөсөн шалтгаан нь дараах хүчин зүйл юм.
  - Эхлэлтийн хурал, дунд үеийн тайлан, үр дүнгийн хурал зэргийн үйл ажиллагаа явуулж байгууллагын гишүүдэд ухамсарлуулах, мэдрүүлэх болон тэдний шинэ санааг цуглуулж байгааг
  - «Харамч бол хамгийн муу, хэмнэлт бол хамгийн сайн сонголт» гэсэн ойлголтоор хэрэгцээт үйл ажиллагааг шууд эхлүүсэн явдал
- Үйл ажиллагаагаар нийт эдийн засгийн үр ашиг (хөрөнгө оруулалт эргэн нөхөх хугацаа 2 жил дотор байх)
  - Жилийн үр дүнгийн өртөг : 5,700,000 иен
  - Хөрөнгө оруулалтын дүн : 4,000,000 иен
  - Хөрөнгө оруулалт эргэн нөхгөх хугацаа : 1 жилийн дотор
- Үйл ажиллагааны хэрэгжилтээр бий болгосон ашгийн тухайд байгууллагын гишүүдэд урамшуулал байдлаар буцаан олгох байдлаар өгхийн тулд нийт сайжруулах багийг байгууллага дотор сайжруулах санал зөвөлгөөний тогтолцоонд үйлдүүлсэн. Ингэснээр гишүүдийн сайжруулах асуудалд хандах хандлага ихэссэн.

#### 7. Цаашдын төлөвлөгөө

- Шинэ сайжруулах багийг идэвхитэй оролцуулах арга хэмжээ авах
- Хамаарал бүхий компаниуд дээр тухайн үйл ажиллагааг идэвхитэйгээр өрнүүлэх, мөн орон нутгийн ажиллагааг идэвхижүүлэхийн тулд ойролцоох компаниуддаа идэвхитэй үйл ажиллагааг танилцуулж, санал болгох.

64

Анхаарал тавьсанд  
баярлалаа



Appendix2.4-12 A Sample of Detailed Energy Audit Plan (for APU)





Эрчим Хүч Хэмнэлтийн Үзлэг оношлогоог гүйцэтгэх төлөвлөгөө ( АПУ үйлдвэр )

Эрчим Хүч хэмнэлтийн энэхүү үзлэг оношлогоог Жайка байгууллагаас хэрэгжүүлж буй УБ хотын Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний хүрээнд дараах зорилгоор зохион байгуулж байна.

- 1) Монгол талын Хамтрагч Талын мэргэжилтэнд эрчим хүч хэмнэлтийн үзлэг оношлогоог хийх болон эрчим хүч хэмнэлтийн багаж төхөөрөмжийг ажиллуулж ашиглах технологийг дамжуулан өвлүүлэх
- 2) Эрчим хүч хэмнэлтийн үзлэг оношлогоог хийснээр эрчим хүчийг тодорхой хэмжээгээр хэмнэх бодит бололцооны талаарх үнэлэлт дүгнэлтийг хийх.
- 3) Эрчим хүч хэмнэлтийн үзлэг оношлогоог хийлгэсэн үйлдвэрүүдэд хандан, үр дүнгээ өгөх эрчим хүч хэмнэлтүүд, арга хэмжээний саналуудыг санал болгон зөвлөх.

Үзлэг оношлогоог дараах байдлаар гүйцэтгэнэ.

1. Үйлдвэрийн нэр : АПУ үйлдвэр
2. Хэрэгжүүлэх өдөр : 2011оны 3 сарын 16, 17-ны өдрүүд
3. Үзлэг оношлогоог гүйцэтгэгч япон мэргэжилтнүүд болон Монгол талаас эрчим хүч хэмнэлтийн дадлагад оролцогчид
  - 1) JICA-гийн мэргэжилтэн : Такахаши Сүсүмү(Цахилгаан хариуцсан мэргэжилтэн ), Хигаки Садао ( Дулаан хариуцсан мэргэжилтэн )
  - 2) Монгол талаас эрчим хүч хэмнэлтийн үзлэг оношлогоонд дадлагажигч : 3-аас 5 орчим хүний бүрэлдэхүүнтэйгээр оролцуулах.
4. Хөтөлбөр (Тухайн нөхцөл байдлаас шалтгаалан бага зэрэг өөрчлөгдөж болно)
  - 1) Эхний өдөр
 

9:30 ~ 11:00 : 1) Мэндчилгээ танилцуулга  
2) Эрчим хүч хэмнэлтийн үзлэг оношлогооны урьдчилсан судалгааны маягтад үндэслэн дараах зүйлсийг урьдчилан тодруулах.

    - Эрчим хүч хэмнэлтийн үзлэг оношлогооны ажлын агуулга болон төлөвлөгөөг нягтлах.
    - Үйлдвэрлэлийн эрчим хүчний тоног төхөөрөмжийн байдал болон үйлдвэрлэлийн эрчим хүчний хэрэглээний байдал.

11:00 ~ 13:00 : Тасралтгүй тоо өгөгдлүүдийг цуглуулахад шаардлагатай хэмжилтийн багаж төхөөрөмжүүдийг суурилуулах, хэмжигчүүдийг ажиллуулж эхлэх.

13:00 ~ 15:30 : Үйлдвэр дээрх судалгааны ажил ( Үдийн хоол, Амралтын цагийг оруулах )

2) Дараагийн өдөр

- 10:00 ~ 13:00 : Үйлдвэр дээрх хэмжилт судалгаа  
(тасралтгүй үргэлжлүүлэх ) ( Үдийн хоол, завсарлагыг цагийг оруулаад )
- 13:00 ~ 14:30 : Хэмжилтийг дуусгах  
Хэмжилтийн тоног төхөөрөмжүүдийг хурааж цэгцлэх
- 14:30 ~ 15:30 : Үйлдвэр дээрх үзлэг оношлогоог хийж дууссаны дараа дараах агуулгаар ярилцлага зохион байгуулах.
- Үйлдвэр дээрх үзлэг оношлогооны талаар судалгаа товч тайлан
  - Цаашдын төлөвлөгөө ( Үзлэг оношлогооны тайланг гаргах тайланг гаргах цаг хугацаа ) -г нягтлах.

5. Эрчим хүч хэмнэлтийн үзлэг оношлогоог хийх үед дагаж Мөрдөх ёстой зүйлүүд:

- 1) Ажлыг гүйцэтгэхэд үйлдвэрийн хариуцах ажилтан заавал хамт байлцана.
- 2) Үзлэг оношлогоог гүйцэтгэгч гишүүд болон оролцогчид нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлэхүйц үйл ажиллагааг огтхон ч явуулж болохгүй. Мөн үзлэг оношлогоог гүйцэтгэгч болон оролцогчид нь орчин тойрныхоо аюулгүй байдалд сайтар анхааран, бэртэж гэмтэхээс болон гал түймэр гаргахаас сайтар сэргийлэн ажиллана.
- 3) Хэмжилтийн багаж болон Сенсоруудыг үйлдвэрийн тоног төхөөрөмжид суурилуулах үед үйлдвэрийн хариуцан дагалдагч ажилтанд төхөөрөмжийг байрлуулах аргачлалыг тайлбарлаж өгсний үндсэн дээр суурилуулалтыг үйлдвэрийн ажилтанаар гүйцэтгүүлнэ.
- 4) Фото зураг авахдаа үйлдвэрийн ажилтнаас зөвшөөрөл авсны үндсэн дээр зураг авна.

6. Эрчим хүч хэмнэлтийн үзлэг оношлогооны ажлын агуулга

- 1) Тасралтгүйгээр тоо өгөгдлийг цуглуулж авах
  - I. Air Compressor-ийг ажиллуулах, тоо өгөгдлүүдийг авах.
  - II. үйлдвэрт Air Compressor (Пивоны үйлдвэр, архины үйлдвэрт)-ийн цахилгаан гүйдэл хэмжигч болон даралт хэмжигч төхөөрөмж (Data Logger 2 ширхэгийг хэрэглэнэ )-ийг 24 цагийн турш ашиглаж хэмжинэ. Гагцхүү архины үйлдвэрт Даралт хэмжигч хошуу байхгүй учраас даралтыг энгийн нүдээр ашиглаж нягтална.

2) Эрчим хүч хэмнэлтийн үзлэг оношлогоонд хамрагдах төхөөрөмж болон шалгах зүйлсүүд

Хамрагдах төхөөрөмж	Шалгах агуулга	Ашиглах төхөөрөмжүүд	Тайлбар
Уурын төхөөрөмж	<ul style="list-style-type: none"> <li>- Хоолойнуудын байрлал</li> <li>- Хоолойнуудын дулаанаа барих байдал ( төхөөрөмж, хавхлага, фланци зэргийг оруулна )</li> <li>- Уурын Тгар –ын марк моделийг сонгох байдал</li> <li>- Уурын Тгар-ын хөдлөх хэсгийн ажиллагааны байдал</li> <li>- Бусад</li> </ul>	Гадаргуун температур хэмжигч, термометр	Товч Схем бүдүүвч зургийг хийх Хүрэлцэж доргион хэмжигчийн ажиллагаа доголдолтой байгаа учраас хэт авианы мэдрэгчтэй оношлогооны төхөөрөмжийг хэрэглэнэ. Үүнээс гадна сайжруулах шаардлагатай зүйл байвал
Халуун усны төхөөрөмжүүд	<ul style="list-style-type: none"> <li>- Хоолойнуудын байрласан байдал</li> <li>- Хоолойнуудын халуунаа барих байдал ( төхөөрөмж, хавхлага, фланц зэргийг оруулна )</li> <li>- Тухайн байран дах пар дулааны төхөөрөмжийн байдал</li> <li>- Тасалгаан доторх дулааны хяналтын байдал</li> <li>- Халуун усны эргэлтийн насосны үйл ажиллагааг хянах ( 1ширхэгийг )</li> <li>- Бусад</li> </ul>	Гадаргуун температурыг хэмжигч, термометр  Хэт авианы долгионоор урсалт хэмжигч, цахилгаан гүйдэл хэмжигч	Товч схем бүдүүвч зургийг хийх  Урсалтын хэмжээ болон оролт гаралтын амын даралтаар насосны ажиллагааны чадавхийг нягтлах Түүнээс гадна сайжруулах шаардлагатай зүйл байвал

Хамрагдах төхөөрөмж	Шалгах агуулга	Ашиглах төхөөрөмжүүд	Тайлбар
Air Compressor	<ul style="list-style-type: none"> <li>- Хоолойнуудын байрласан байдал</li> <li>- Ажиллагааны тоон өгөгдлүүдийг авах ( 5-1. заалт ) -ийн үр дүнд тулгуурласан ажиллагааны байдал</li> <li>- Нягтруулсан агаар алдагдаж буй байгаа байдал. ( хэрэглэгч тоног төхөөрөмжүүдийг мөн хамруулна )</li> <li>- Сорох агаарын сорогдон орж буй оролтын байдал</li> <li>- Хөргөлтийн төхөөрөмжөөс гарах агаарыг хааш нь гадагшлуулдаг эсэхийг</li> <li>- Бусад</li> </ul>	Data Logger, Цахилгаан гүйдлийн Clamp Meter, on Tester, даралтын Трансметр Хэт авианы долгионы мэдрэгч болон Clamp type-ийн цахилгаан гүйдэл хэмжигч	Товч Схем бүдүүвч зургийг хийх  Бусад сайжруулах шаардлагатай зүйлс байвал
Гэрэлтүүлгийн төхөөрөмж	<ul style="list-style-type: none"> <li>- Гэрэлтүүлгийн төхөөрөмжийн байдал</li> <li>- Гэрэлтүүлгийн төхөөрөмжийг хянаж буй байдал</li> <li>- Бусад</li> </ul>		Бусад сайжруулах шаардлагатай зүйл байвал
Агааржуулалтын төхөөрөмжүүд	<ul style="list-style-type: none"> <li>- Агааржуулалтын төхөөрөмжүүд ( Кондишнёр болон халаалт ) ын төхөөрөмжийн байдал</li> <li>- Тасалгааны доторх температурыг хянах байдал</li> <li>- Бусад</li> </ul>	Дулаан цахилгаантай харьцах температур хэмжигч	Бусад сайжруулах шаардлагатай зүйл байвал
Бусад			Бусад сайжруулах шаардлагатай зүйл байвал

7. Эрчим хүч хэмнэлтийн үзлэг оношлогооны тайланг бэлтгэж гаргах.

- 1) Үзлэг оношлогоог гүйцэтгэгч мэргэжилтэн нар аль болох хурдан хугацаанд нэгтгэж гаргана. ( Зорилт : 2 долоо хоногийн дотор )
- 2) Эрчим хүч хэмнэлтийн үзлэг оношлогооны тайланд дараах зүйлүүдийг хамруулан тусгана.
  - Одоогийн нөхцөл байдал дээрх хүндрэлтэй асуудлууд
  - Эрчим хүч хэмнэлтийн арга хэмжээ болгон Санал болгох саналууд ( бүхий л боломжит хувилбараар, тодорхой хэмжээгээр эрчим хүч хэмнэх хэмнэлтийн үр дүн болон оруулах хөрөнгө оруулалтын нөхөн төлөгдөлтийн хугацаа зэргийг

бичнэ )

8. Эрчим хүч хэмнэлтийн үзлэг оношлогооны үр дүнгийн тайлан
  - 1) Үйлдвэр дээр очиж, үйлдвэрийн холбогдох ажилтан нарт эрчим хүч хэмнэлтийн үзлэг оношлогооны үр дүн( үзлэг оношлогооны тайлан )гийн талаар танилцуулна.
  - 2) Тайланг 1 сарын хугацаанд гаргахаар зорьж төлөвлөж байгаа ба монголоор орчуулах шаардлагатай байгаагийн дээр үйлдвэрийн удирдлага болон үзлэг оношлогоонд оролцогчдод өгөх тайлбарын тухайд үзлэг оношлогооны мэргэжилтэн нар дахин монголд ирэх үед зохион байгуулахаар төлөвлөж байна.

